

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2024 – 10 САР | ДУГААР 71

ГАРЧИГ



2–3 Бодлогын нийтлэл

4–6 Зохицуулалтын мэдээ

7–8 Байр суурь

9–11 Тогтвортой санхүүжилт

12–13 Компанийн засаглал, комплайнс

14–15 Финтек ба регтек


16–23 Судлаачийн индэр

24–25 Хадгаламж, зээлийн хоршооны гишүүнчлэл гэж юу вэ?

26–27 Олон улсын зах зээлийн мэдээ

28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫГ ТАТАХ ЧИГЛЭЛД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭНҮҮД




Сүүлийн жилүүдэд манай улсын хөрөнгийн зах зээлийн хөгжилд өндөр өсөлт гарч байгаа нь статистик тоон мэдээллээс харагдаж байна. Үүнд юу нөлөөлсөн бэ? Бодлого зохицуулалтын орчин ямархуу байна вэ?

Монгол Улсын хөрөнгийн зах зээл сүүлийн жилүүдэд хурдацтай тэлж, өндөр өсөлтүүд гарч байна. Тухайлбал, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн гол индикатор болох зах зээлийн үнэлгээ 2024 оны III улирлын байдлаар 12.1 их наяд төгрөгт хүрсэн нь 2023 оны дотоодын нийт бүтээгдэхүүний 17.2 хувьтай тэнцэж байна. Зах зээлийн үнэлгээг 2020 онтой харьцуулахад 4.6 дахин өссөн үзүүлэлт бөгөөд энэхүү өсөлтөд УИХ, ЗГ-аас эдийн засгийг төрөлжүүлэх, тэр дундаа банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах, банкны салбарын реформыг хэрэгжүүлэх болон төрийн өмчит хувьцаат компаниудыг хувьчлах бодлогыг авч хэрэгжүүлсэн нь зах зээлийн өсөлтөд голлох нөлөөг үзүүллээ.

Үүний сацуу энэхүү өсөлтийг хадгалах, үргэлжлүүлэхэд шаардлагатай бодлого зохицуулалтын оновчтой арга хэмжээнүүдийг шат дараатай авч хэрэгжүүлсээр байна. Тухайлбал, Улсын Их Хурал, Засгийн газраас санхүүгийн зах зээлд өрсөлдөөнийг бий болгох, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлд анхаарал хандуулсантай холбоотойгоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулан олон улсын хөрөнгийн зах зээл дээрх шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх эрх зүйн орчин бүрдэж, хөрөнгө оруулалт нэмэгдэх, улмаар хувийн хэвшлийн компаниуд хөрөнгийн зах зээлээр дамжуулан урт хугацаат санхүүжилт татах үйл явц хялбаршиж, дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхол, санхүүгийн зах зээл дээрх мөнгөн урсгал нэмэгдэх боломж бүрдээд байна.

Үүнтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой эрх зүйн орчныг сайжруулан холбогдох дүрэм, журмын орчныг боловсронгуй болгон ажиллаж байна. Ингэснээр дотоодын зах зээлд санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо өсөж, үнэт цаасны арилжааны идэвх нэмэгдэн, хууль эрх зүйн орчин олон улсын жишигтэй нийцэж, мэргэжлийн хөрөнгө оруулагчид нэмэгдэж, улмаар гадаадын хөрөнгө оруулагчдад таатай зах зээл бий болох ач холбогдолтой юм.

Үргэлжлэлийг 7-р нүүрт



ЁС ЗҮЙ

Ёс зүй нь албан хаагчид үйл ажиллагааныхаа бүхий л хүрээнд баримтлах ёс суртахууны зарчмууд, эрхэмлэх зүйлс юм. Эдгээр ёс суртахууны зарчимд үнэнч шударга байх, шударга байдал, шударга зан суртахуун, хичээл зүтгэл, итгэлцэл, хүндэтгэл, зарчимч тууштай байх гэсэн үзэл баримтлалууд багтдаг. Ёс зүйд сонирхлын зөрчил, албан тушаалаа зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх явдал мөн хамаарна.



EETHICS

Ethics are the moral principles or values that guide officials in all aspects of their work. Ethical behaviour encompasses the concepts of honesty, integrity, probity, diligence, fairness, trust, respect and consistency. Ethical behaviour includes avoiding conflicts of interest, and not making improper use of an individual's position.

Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ФАКТОРИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нэхэмжлэхийг худалдан авч, санхүүжилт олгодог "фактор" гэсэн нэр томъёо нь латины "facere" гэдэг үгнээс гаралтай бөгөөд эртний Вавилоны иргэншлийн үед холын зайд худалдаа эрхэлдэг худалдаачид бараагаа зорьсон газартаа хүргэж, орлого олох хүртэл багагүй хугацаа шаарддаг байснаас мөнгөний бэрхшээлтэй тулгарч, арилжааны авлагынхаа тодорхой хувийг зуучлагчдад худалдах болсноор факторингийн анхны хэлбэр үүссэн байна.

Дундад зууны үеэс Европыг дорнодтой холбосон томоохон худалдааны төвүүд Италийн Венец, Флоренс зэрэг хотод төвлөрч, худалдааны саадгүй урсгалыг хангах санхүүжилтийн болон зээлийн үйлчилгээ дэлгэрч байсан бол аж үйлдвэрийн хувьсгалын үеэс худалдаа, арилжаа өргөжиж, үйлдвэржилт явагдахын хэрээр эргэлтийн хөрөнгийн эрэлт нэмэгдэж, тэдгээрийн санхүүгийн хэрэгцээг хангахын тулд төрөлжсөн факторинг компаниуд бий болж, зам тээврийн хөгжлийг даган хөгжлийн өнөөгийн шатанд хүрсэн байна.

Улмаар технологийн дэвшил нь факторингийн үйлчилгээнд хувьсгал хийж, цахим платформуудыг ашиглах болсноор оновчтой, үр ашигтай, шуурхай гүйлгээ хийх боломжийг олгох болсон нь захиргааны ачааллыг бууруулж, өгөгдлийн аналитикийг шийдвэр гаргалтад ашиглах болсноор зээлийн хяналт, цуглуулалт, эрсдэлийн удирдлага, нэхэмжлэхийн баталгаажуулалт зэрэг олон төрлийн шийдлүүдийг санал болгодог санхүүгийн цогц үйлчилгээ болон өргөжсөн байна.

Манай орны хувьд Улсын Их Хурлаас 2002 онд соёрхон баталсан Иргэний хуулийн 123 дугаар зүйлээр шаардах эрх шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулж, факторингийн үйлчилгээг банк бус санхүүгийн эрхлэх үйл ажиллагааны төрөлд хамааруулан салбар эрх зүйгээр зохицуулахаар эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Сүүлийн жилүүдэд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ гүнзгийрч, факторингийн үйлчилгээний ач холбогдол нэмэгдэхийн хэрээр олон улсын жишигт нийцсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээг оновчтой авч хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Төрөөс жижиг, дунд бизнес эрхлэгчдийг бодлогоор дэмжих, нийгэм эдийн засагт гүйцэтгэх үүрэг оролцоог нэмэгдүүлэх олон талт арга хэмжээний нэг нь нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийг нэвтрүүлэх явдал бөгөөд Санхүүгийн зохицуулах хороо, Дэлхийн банкны бүлгийн гишүүн байгууллага болох Олон улсын санхүүгийн корпорацитай (ОУСК) Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төслийн хүрээнд хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичгийг 2020 оны 5 дугаар сард байгуулан ажиллаж байна.

Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт нь аж ахуйн нэгжүүдийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх, зардлыг бууруулах, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг

хангах хийгээд дотоодын болон олон улсын хэмжээнд эцсийн хэрэглэгчдэд бараа бүтээгдэхүүнийг хүргэх нийлүүлэлт, түгээлтийн сүлжээний худалдаа, санхүүгийн урсгал, эрсдэлийн менежмент, санхүүжилтийн үйл ажиллагааг тэтгэх өргөн хүрээний ач холбогдолтой юм.

2024 оны эхний хагас жилийн дүн мэдээгээр факторингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 57 ББСБ 22.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.2 дахин өссөн үзүүлэлтэй байх ба нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт нь манай орны түүхэн уламжлалт онцлог болох хөдөө аж ахуйн салбар тэр дундаа мах, махан бүтээгдэхүүн, сүү, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй уялдан хөгжиж байна.

Үүний зэрэгцээ системийн нөлөө бүхий арилжааны 2 банканд факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгосноор үйлдвэрлэгч, бэлтгэн нийлүүлэгчийн авлага санхүүжүүлэх үйл ажиллагаа эрчимжиж, банкны салбарт факторингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч, санхүүгийн байгууллага буюу гурван талыг холбосон эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг хангах технологид суурилсан цогц шийдэл бүхий “Cashme”

цахим дундын платформыг нэвтрүүлж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос факторингийн үйлчилгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох, санхүүжилтийн төрөлжсөн институтыг бэхжүүлэх зорилгоор Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хуралд өргөн барьсан бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар факторингийн компанийн хөгжлийг шинэ шатанд гарна гэсэн хүлээлттэй байна.

Цаашид факторингийн үйлчилгээг хөгжүүлэхэд үйлчилгээ эрхлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.16-д “шаардах эрхийг худалдан авах замаар санхүүжилт хийх (факторинг, форфайтинг зэрэг тэдгээртэй адилтгах хэлцэл)-ийг нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах бараа үйлчилгээнд хамруулсныг санхүүгийн бусад үйлчилгээтэй ижил төстэй татварын орчноор дэмжих зэрэг бодлого, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар жижиг дунд бизнесийн түншлэлийн таатай орныг бүрдүүлэх нь зүйтэй байна.



ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.АМАРБЯЭСГАЛАН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД АЖИЛЛАЛАА



УИХ-ын дарга Д.Амарбаясгалан Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн хамт Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаатай танилцлаа. Уулзалтын эхэнд УИХ-ын дарга Д.Амарбаясгалан хууль, эрх зүйн “гурван төгөлдөршил” бодлогын хүрээнд хэм, хэмжээний зохицуулалтыг хуулиар, бусад үйл ажиллагааны шинж чанартай асуудлыг холбогдох журмаар зохицуулах, орон нутагт амьдарч буй иргэдэд санхүүгийн олон төрөлт үйлчилгээг хүргэх хүртээмжийг нэмэгдүүлэх мөн ногоон санхүүжилтийг хөгжүүлэхэд анхаарч ажиллахыг онцолсон юм.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан үүний дараа санхүүгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, салбаруудад хэрэгжүүлж буй бодлого зохицуулалт, онцлох ажлуудынхаа талаар товч мэдээлэл танилцуулав. Сүүлийн жилүүдэд холбогдох хуулиудад орсон нэмэлт өөрчлөлт, шинээр батлагдсан эрх зүйн орчинтой холбоотойгоор Хорооны чиг үүрэг нэмэгдэж нийт 11 салбарт хамаарах 6,370 зохицуулалттай этгээдэд хяналт, зохицуулалт тавьж ажиллаж байна. Зохицуулалттай салбарын үнэлгээ ДНБ-ий 27.8 хувьтай тэнцэх хэмжээнд өргөжин хөгжсөн бөгөөд тэр дундаа хөрөнгийн зах зээл сүүлийн жилүүдэд тогтмол өндөр өсөлтийг үзүүлж байна. Тухайлбал системийн нөлөө бүхий банкнууд, төрийн өмчит компаниудын хувьчлал амжилттай хэрэгжиж хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 5.9 их наяд төгрөгөөр нэмэгдэж, 2.2 дахин өсөөд байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулан ААНОАТХ, ХХОАТХ-иудад нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд уг өөрчлөлтөөр гадаадын хөрөнгө оруулагчийн албан татвар ногдох орлогыг дотоодын хөрөнгө оруулагчтай ижил тэнцүү, ялгаваргүй байдлаар суутган тооцох, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчаас үл хамааран үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024–2026 онд 90 хувиар, 2027–2029 онд 50 хувиар тус тус хөнгөлөх хуулийн зохицуулалт бий болсон. Мөн

дотоодын хөрөнгийн зах зээлийг олон улсын түвшинд гаргах, Ази, Номхон далайн орнуудын хөрөнгийн зах зээлтэй холбох, компаниудыг гадаадын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх, хадгаламжийн бичиг гаргах, гадаадын хөрөнгө оруулагчийг татах зорилгоор “Mongolia’s Capital Market Connectivity: Hong Kong”, “Shanghai” цуврал арга хэмжээг зохион байгуулсан. Түүнчлэн даатгалын салбарыг хөгжүүлэх чиглэлд даатгалын багц хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, үзэл баримтлалыг батлуулсан бөгөөд хуулиуд шинэчлэн батлагдсанаар урт хугацаат даатгал, давхар даатгал, болон заавал даатгалын харилцааг хөгжүүлэх эрх зүйн орчин сайжирна гэсэн хүлээлттэй байна. Мөн ногоон санхүүгийн салбар болон цахим технологид суурилсан санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлд хэрхэн ажиллаж байгаа талаар танилцуулав.

Мэдээлэл, танилцуулгын дараа Эдийн засгийн байнгын хорооны гишүүд Хорооны удирдлагуудаас холбогдох асуудлуудын талаар тодруулга, хариулт авлаа. Санхүүгийн салбар сүүлийн жилүүдэд өндөр өсөлтийг үзүүлэхийн зэрэгцээ мөнгө угаах өндөр эрсдэлтэй орнуудын саарал жагсаалтаас түргэн хугацаанд гарахад Санхүүгийн зохицуулах хорооны оруулж буй хувь нэмрийг онцлон дурдаад цаашид энэ эрчээ алдалгүй ажиллахын зэрэгцээ салбарын хууль, эрх зүйн орчны шинэчлэлийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллахаа илэрхийлсэн юм.

“НОГООН БОНД”-ЫН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЖ ЦАН ЦОХИЛОО

“ХААН банк” ХК-ий нийтэд санал болгон гаргаж буй бондын анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх цан цохих ёслол боллоо.



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс “Ногоон таксономи”-г 2019 онд, “Үндэсний тогтвортой санхүүжилтийн замын зураг”, “Тогтвортой хөгжлийн

зорилтуудын санхүүжилтийн таксономи”-ийг өнгөрсөн онд тус, тус баталсан. Мөн Санхүүгийн зохицуулах хороо “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталснаар дотоодын компаниудаас ногоон бонд гаргах замаар байгаль орчинд ээлтэй төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх тогтолцоо бүрдэхэд чухал ач холбогдолтой алхам болсон. Өөрөөр хэлбэл Монгол Улсын тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжиж ажиллах, дотоодын байгууллагууд байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагаа явуулахад дэмжлэг болгож тогтвортой санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, олон улсын хөрөнгө оруулагчдад ногоон хөрөнгө оруулалтын сонголтыг бий болгох зорилтын хүрээнд дотоодын анхны ногоон бондыг системийн нөлөө бүхий банкнуудын нэг болох “ХААН банк” ХК гаргасан. “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д тусгасан бондын хөтөлбөр хэрэгжүүлэх буюу тухайн компани нэг удаа бондоо бүртгүүлээд санхүүжилтийн хэрэгцээ, шаардлага байгаа үедээ хэсэгчлэн бондоо гаргах боломжтой зохицуулалтын хүрээнд энэ удаагийн бондыг нийтэд санал болгон гаргаснаар хөрөнгийн зах зээлд шинэ төрлийн бүтээгдэхүүн дахин нэгээр нэмэгдэж байгаад баяртай байна” гэдгийг онцолсон юм.

Төгрөгийн болон ам.долларын хосолсон хэлбэрээр энэхүү бондыг гаргаж байгаагаараа онцлогтой бөгөөд өнгөрөгч онд эхний хөтөлбөрийн хүрээнд 36 сарын хугацаатай, 16 хувийн хүүтэй, 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 17 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн. Харин энэ онд хоёр дахь удаагийн хөтөлбөрөөр арилжаалж буй бондоос 36 сарын хугацаатай, 100 ам.долларын нэрлэсэн үнэтэй, нийт 25 сая ам.долларыг татан төвлөрүүлэхээр төлөвлөж, арилжааг эхлүүлсэн даруйд дотоодын зах зээлд гарч буй анхны ногоон бондын хөтөлбөрийн санхүүжилтээ 100 хувь амжилттай татан төвлөрүүлээ.

ДААТГАЛЫН ЖУРМЫН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ




Санхүүгийн зохицуулах хороо “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”, “Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа авто тээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгчийг жолоочийн даатгалд хамруулах журам”-д нэмэлт,

өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Эдгээр журамд оруулж буй нэмэлт, өөрчлөлтийн талаар танилцуулж, санал солилцох хэлэлцүүлгийг даатгалын салбарын оролцогчдын дунд зохион байгууллаа.

Олон улсын хөгжлийн чиг хандлага, сайн жишигт суурилан “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-д даатгалын байгууллага цахим болон аливаа дэвшилтэт технологийг ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх, даатгалын үйл ажиллагаа, даатгалын орлогын шимтгэлийг ил тод, нээлттэй болгох хүрээнд оруулсан холбогдох нэмэлт, өөрчлөлтийг энэ үеэр танилцуулав. Мөн “Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа авто тээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгчийг жолоочийн даатгалд хамруулах журам”-д хилийн бүсэд даатгалын үйл ажиллагаа явуулах зохицуулалтыг боловсронгуй болгох, даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Хил хамгаалах ерөнхий газартай хамтран боловсруулсан нэмэлт, өөрчлөлтийг танилцуулж, санал солилцоо. Хэлэлцүүлэгт Хил хамгаалах ерөнхий газар, даатгалын компаниуд болон даатгалын холбооны төлөөлөл оролцсон юм.

OTC MARKETS GROUP-ТЭЙ ХАМТРАН ВЕБИНАР ЗОХИОН БАЙГУУЛАВ




Санхүүгийн зохицуулах хороо дотоодын хөрөнгийн зах зээлийг олон улсын хөрөнгийн зах зээлтэй холбох зорилгоор сургалт вебинарыг цуврал болгон тогтмол зохион байгуулж байна. Энэ удаад OTC markets group, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Capital markets Mongolia байгууллагуудтай хамтран “NAVIGATING OTC MARKETS: A PATHWAY TO CAPITAL FOR GLOBAL ISSUERS” вебинар зохион байгууллаа.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан арга хэмжээг нээж “Монгол Улсын хөрөнгийн зах зээл сүүлийн жилүүдэд хурдацтай тэлж, өндөр өсөлтүүдийг үзүүлсээр байна. Санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд олноор гарч, үнэт цаасны арилжааны идэвх нэмэгдэх боллоо. Хууль, эрх

зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлснээр гадаадын хөрөнгө оруулагчдад таатай зах зээл бий болсны зэрэгцээ мэргэжлийн хөрөнгө оруулагчид ч нэмэгдэж байгааг дуулгахад таатай байна. Иймд бид цаашид ч хөрөнгийн зах зээлээ олон улсын зах зээлтэй холбох, гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг манай улсын хөрөнгийн зах зээлд оролцох идэвх, сонирхлыг нэмэгдүүлэх, дотоодын компаниудад урт хугацааны санхүүжилтээ олон улсын хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлэхэд бодлогоор дэмжих, татвар, эрх зүйн зохицуулалтын таатай орчныг бүрдүүлэхэд үргэлжлүүлэн анхаарч ажиллах болно” гэдгийг онцолсон юм.

Вебинараар OTC markets group-ийн Азийн бүс хариуцсан дэд ерөнхийлөгч Stephen Shipley OTC markets group дээр хувьцаагаа хэрхэн арилжих, хоёрдогч зах зээл дээр хөрвөх чадвараа нэмэгдүүлэх боломж, шалгуур, шаардлагын талаар танилцууллаа. Мөн бусад боломжит хөрөнгийг хэрхэн татан төвлөрүүлэх, арилжих хэрэгслүүдийн талаар мэдээлэл өгч, сонирхсон асуултад нь хариулт өгсөн юм.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА



Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөлийн ээлжит хурал боллоо. Хуралдаанаар “Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан Засгийн газар, аймаг, нийслэлийн болон Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаасыг борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, суутган тооцох, төсөвт төлөх, тайлагнах журам”-ын хэрэгжилт, уул уурхайн биржийн арилжааны өнөөгийн болон цаашдын нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын сангийн хөгжлийн чиг хандлага, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд чиглэгдсэн татварын бусад дэмжлэг зэрэг асуудлыг хэлэлцлээ.

Мөн хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн арилжаа, төлбөр тооцооны системийн шинэчлэл, өнөөгийн нөхцөл байдлын талаар санал солилцож, холбогдох байгууллагууд нарийвчилсан саналаа эргэж танилцуулахаар болов. Түүнчлэн уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг зуучлагч /брокер/-аар дамжуулан арилжаалахтай холбогдуулж зах зээлд үүсэж буй

нөхцөл байдлын талаар холбогдох брокеруудаас ирүүлсэн саналыг хэлэлцээд бодлогын зөвлөмж гаргахаар хуралдаанаар шийдвэрлэлээ.

АНДМУТБ-ААС МОНГОЛ УЛСЫН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОНЦОЛЛОО



Монгол Улс нь Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын төрлийн бүс нутгийн байгууллага болох Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АНДМУТБ)-т 2004 онд гишүүн орноор элссэн. ФАТФ-ын АНДМУТБ-ийн жилийн чуулга уулзалт Арабын Нэгдсэн Эмират Улсын Абу Даби хотноо есдүгээр сарын 22–27-ны өдрүүдэд болж, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хамтын ажиллагааны зөвлөлийн дарга Н.Хүдэрчулуун оролцлоо. Чуулга уулзалтаар Тимор Лесте, Науру, Маршаллын арлууд, Папуа нью гвинеа улсуудын харилцан үнэлгээний тайлан, Вьетнам, Непал Улсын ахицын тайланг хэлэлцэж батлав. Түүнчлэн Мьянмар Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй буюу “саарал жагсаалт”-д орсонтой холбоотой тус улсын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг тусгасан явцын тайланг үнэлгээчид танилцуулж, гишүүн улсуудаар хэлэлцүүлж, батлав.

Санхүүгийн зохицуулах хорооноос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг ФАТФ-ын Техникийн зөвлөмж 15 (Шинэ технологи)-д нийцүүлж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой шаардлагуудыг мөрдүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх чиглэлээр шат дараалсан арга хэмжээг авч ажилласан. Үүнийг АНДМУТБ-аас сайшааж чуулганы үеэр танилцуулах хүсэлтийг тавьсны дагуу виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээгээ танилцуулж, туршлагаасаа хуваалцсан юм.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх, олон улсын стандарт, ФАТФ-ын зөвлөмжтэй нийцүүлж ажиллахтай холбоотой Макао, Малайз улсаас туршлага судлах, сургалт авах хүсэлтийг манай улсад тус тус ирүүлээд байна.

БАЙР СУУРЬ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫГ ТАТАХ ЧИГЛЭЛД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

“Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийн энэ удаагийн байр суурь булангаар Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөнтэй Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсад таниулах, сурталчлах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар ярилцлаа.

Эхлэл 1-р нүүрт



Сая дурдсанчлан Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор хувьцааны хамтын санхүүжилт, банкнаас гаргасан хадгаламжийн сертификат, үнэт цаас зээлэх, зээлдүүлэх зэрэг санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан шүү дээ. Тэгвэл өөр ямар санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх боломжтой вэ?

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын итгэмжлэлийг (REITs) Монгол Улсад нэвтрүүлэх боломжийн талаар туршлага судлахаар Бүгд Найрамдах Турк Улсын Хөрөнгийн Зах Зээлийн Зохицуулах Хороо (СМВ)-той уулзалт хийсэн бөгөөд тус албан уулзалтын үр дүнд Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын итгэмжлэлийн зохицуулалтын орчныг Монгол Улсад бий болгох, холбогдох бодлого, дүрэм, журмыг боловсруулах чиглэлд тэдний зүгээс дэмжлэг үзүүлж ажиллахаар болсон.

Мөн тус Хороотой хамтран Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын итгэмжлэлийн зохицуулалт болон хяналт, шалгалтын чиглэлээр шаардлагатай мэдээ, мэдээлэлээр

албан хаагчдаа хангах зорилгоор сургалт зохион байгуулж, хамруулсан.

Хэдийгээр хууль тогтоох эрх мэдэл бидэнд байхгүй ч, манай салбарын эрх зүйн зохицуулалт гэдэг утгаараа хууль зүйн үндэслэл, шаардлага болон хууль боловсруулах ажлын хэсэг зэрэгт Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл орж ажиллах нь гарцаагүй. Энэ ч утгаараа бид REITs-ийн үйл ажиллагааны талаарх зохицуулалтын орчны талаар холбогдох судалгааг хийж байна.

Сүүлийн жилүүдэд Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсад таниулах, сурталчлах, гадаадын хөрөнгө оруулагчдын идэвх сонирхлыг нэмэгдүүлэх тал дээр ихээхэн анхаарал хандуулан ажиллаж байна. Энэ тал дээр Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс ямар арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллаж байгаа талаар манай сэтгүүлийн уншигчдад дэлгэрэнгүй мэдээлэл өгөөч.

Манай улсын хөрөнгийн зах зээлийн хөрөнгө оруулагчдын бүтэц буюу арилжаанд оролцож буй байдлаар нь авч үзвэл одоогоос 10 гаран жилийн өмнө, тодруулбал 2012 онд буюу ид уул уурхайн салбарын оргил үеэр гадаадын хөрөнгө оруулагчид нийт арилжаанд оролцогчдын 92.6 хувийг эзэлж байсан ч жил бүр энэ тоо эрс буурсан бөгөөд одоогоор арилжаанд оролцогчдын 3 хүрэхгүй хувь нь гадаадын хөрөнгө оруулагч байдаг. Мөн хувьцааны хөрвөх чадварын үзүүлэлтээр ч маш доогуур байна. Тухайлбал 2024 оны III улирлын байдлаар хөрвөх чадварын үзүүлэлт 1.8 хувьтай тооцоологдсон байна. Иймд манай улс хөрөнгийн зах зээлээ дараагийн шатанд аваачихад мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг татах, арилжааны идэвхийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагууд тулгарсан.

Бидний зүгээс энэ тоог нэмэгдүүлэх, гадаад хөрөнгө оруулагчдыг татах хүрээнд олон улсын хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, нэн ялангуяа хөрөнгийн зах зээлийг гадаадын хөрөнгийн зах зээлтэй холбох, хөрөнгө оруулагч нарт сурталчлах, дотоодын аж ахуйн нэгжүүдийг олон улсын зах зээлээс хөрөнгө оруулалт татахад дэмжлэг үзүүлэх чиглэлд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Энэ хүрээнд бидний зүгээс олон улсын зохицуулагч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа тэлэх, мөн зах зээлээ олон улсад таниулан сурталчлах чиглэлээр цуврал арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал, өнгөрсөн жил “Mongolian capital markets day-2023” арга хэмжээг БНХАУ-ын Шанхай хотод, “Mongolia’s Capital Market Connectivity” арга хэмжээг БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгд, мөн энэ оны 4 дүгээр сард “Монголын хөрөнгө оруулалтын долоо хоног” арга хэмжээг Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк хотноо зохион байгуулсан бол дараа сард Бүгд Найрамдах Сингапур Улсад “Mongolia’s Capital Market Connectivity” арга хэмжээг зохион байгуулах гэж байгааг дуулгахад таатай байна.

Тус арга хэмжээгээр дамжуулан гадаадын хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгч болон бусад зах зээлийн оролцогч нарт Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал болон арга хэмжээ зохион байгуулж буй улс дахь хөрөнгийн бирж дээр үнэт цаас гаргах, давхар бүртгүүлэх боломжийн талаар мэдээлэл түгээх зорилготой юм.

Үүнээс гадна хөрөнгийн зах зээлийг олон улсын хөрөнгийн зах зээлтэй холбох, олон нийтийг хөрөнгийн зах зээлийн мэдээ, мэдээллээр хангах зорилготой сургалт, вебинарыг энэ онд удаа дараа зохион байгуулсан. Цаашдаа ийм төрлийн сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулах уу?

Мэдээж тэгэлгүй яах вэ. Санхүүгийн зохицуулах хорооноос дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, олон улсын хөрөнгийн зах зээлтэй холбох, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурь тогтолцоог сайжруулах хүрээнд холбогдох сургалт вебинарыг цуврал болгон тогтмол зохион байгуулж байна. Тухайлбал, Торонтогийн Хөрөнгийн Бирж болон холбогдох байгууллагатай хамтран давхар бүртгэл, гадаадын үнэт цаас гаргагчид тавигдах нөхцөл, шаардлага, бүртгэлийн

онцлох зохицуулалтууд болон тайлагналын шаардлагын талаарх “Opportunities on Toronto Stock Exchange: Navigating listings & Regulations”, Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтран Лондонгийн хөрөнгийн биржийн зохицуулалт, биржид бүртгүүлэх шалгуур, шаардлагын талаарх “Unlocking Capital: Opportunities on the London Stock Exchange”, OTC markets group болон холбогдох байгууллагатай хамтран OTC markets group дээр хувьцаагаа хэрхэн арилжих, хоёрдогч зах зээл дээр хөрвөх чадвараа нэмэгдүүлэх боломж, шалгуур, шаардлагын талаарх “Navigating OTC Markets: A Pathway To Capital For Global Issuers” вебинарыг тус тус зохион байгуулсан.

Цаашид ч манай байгууллагын зүгээс Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын хөрөнгийн зах зээлтэй холбох чиглэлээр олон төрлийн сургалт, вебинарыг тогтмол зохион байгуулах, бодлого зохицуулалтын орчныг илүү сайжруулахаар зорин ажиллана.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс ирэх онуудад үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр бодлого зохицуулалтын өөр ямар арга хэмжээ цаашид авч хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байгаа вэ?

Юуны өмнө сая дурдсан арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэхээс гадна ТОП-100 хөтөлбөрийн хүрээнд аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах сонирхлыг нэмэгдүүлэх, төрийн өмчит компаниудын хувьчлалыг үргэлжлүүлэх, мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хамтын хөрөнгө оруулалтын сан, даатгалын компани, банк, банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаасны компаниудын идэвх оролцоог өсгөж, бодлогоор дэмжих замаар хөрөнгө оруулагчдын суурийг бэхжүүлэх, гадаад, дотоодын аж ахуйн нэгжээс ногоон, нийгмийн болон жендер бонд гаргах зохицуулалтын таатай орчныг бүрдүүлэх, цахим технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх зэрэг салбарын цар хүрээг нэмэгдүүлэх чиглэлд ихээхэн анхаарч, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх болно. Мөн иргэд олон нийтийг хөрөнгийн зах зээлийн мэдлэг мэдээллээр хангах зэрэг ажлыг тогтмол зохион байгуулахаар төлөвлөж байна.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

НОГООН/ТОХ–Д ЧИГЛЭСЭН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ


Ногоон/Тох–д чиглэсэн бонд нь ногоон төслүүдийг санхүүжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, түүнтэй холбоотой сорилтуудыг шийдвэрлэх чухал хэрэгсэл юм (Worldbank 2021). Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн хүрээлэн буй орчны доройтол, цөлжилт, цаг агаарын гамшигт үзэгдлийн тоо хурдтайгаар нэмэгдэж, хөдөө аж ахуй, хүнс, усны аюулгүй байдал алдагдах эрсдэл нэмэгдэж байна (UNDP 2023). Эдгээр бэрхшээлийг шийдвэрлэх байгаль орчны төслүүдийг хөрөнгийн зах зээл, хөрөнгө оруулагчидтай холбож, хөрөнгийг тогтвортой хөгжилд чиглүүлэх нь чухал бөгөөд ногоон/Тох–д чиглэсэн бонд нь эдгээрийг холбох гүүр болж байна.

Маврики Улсын тогтвортой бонд гаргах удирдамжид тодорхойлсноор **Тогтвортой бонд** нь ногоон, эсхүл нийгмийн тогтвортой байдалтай холбоотой төслүүдийг санхүүжүүлэх, хөрөнгө босгох замаар тогтвортой хөгжлийн зорилтод чиглэсэн санхүүгийн хэрэгсэл юм. Харин **уур амьсгалын бонд** нь уур

амьсгалын өөрчлөлтийн шийдлүүдэд зориулж санхүүжилт босгох зорилгоор гаргадаг бол цэнхэр бондын зарцуулалт нь далай, далайн экосистемийн тогтвортой байдлыг хангахад чиглэдэг. Уур амьсгалын болон **цэнхэр бонд** нь ногоон бондын дэд хэсэг бөгөөд эдгээр бондын орлогоор хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл нь байгаль орчинд нэмэлт үр өгөөжийг авчирна гэж үзсэн тохиолдолд эдгээр бондыг **ногоон бонд** гэж нэрлэж болдог. Бондыг ялгах гол зүйл нь салбар, төслийн чиглэл болон холбогдох нөлөөллийн үзүүлэлтүүд байдаг. Ногоон/Тох–д чиглэсэн бондыг ердийн бондын нэгэн адил засгийн газар, үндэстний банк болон бусад санхүүгийн байгууллагууд гаргаж болно.


Мөн доорх зурагт ногоон, нийгмийн болон тогтвортой бондын хамаарлыг, хүснэгтэд ногоон/ Тох–д чиглэсэн бондын төрлүүдийн тодорхойлолтыг тус тус харууллаа.

Зураг. Ногоон, Нийгэм, Тогтвортой бондын хамаарал



Эх сурвалж: Guide for the issue of sustainable bonds in Mauritius (2021)

Зураг. Ногоон, Нийгэм, Тогтвортой бондын хамаарал




Эх сурвалж: Guide for the issue of sustainable bonds in Mauritius (2021)

Нэмж дурдахад, 2050 он гэхэд нүүрстөрөгчийн хийг 0 түвшинд хүргэхээ зарласан улс орнуудад ногоон, нийгмийн бондын зарчим болон тогтвортой байдлын бондын удирдамжид нийцсэн өрийн хэрэгсэл буюу Уур амьсгалын шилжилтийн бонд гарч эхэлсэн. Уур амьсгалын шилжилтийн бонд нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхээр төлөвлөж буй компаниас хэрэгжүүлж буй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн урт

хугацааны стратеги, төлөвлөгөөг дэмжих санхүүжилт юм. Тус бондын орлогыг газрын тос, байгалийн хий, химийн бодис, цемент, ган зэрэг эдийн засагт чухал ач холбогдолтой боловч богино хугацаанд нүүрстөрөгчийг бууруулах боломжгүй салбаруудад зарцуулдаг бол уур амьсгалын бонд нь сэргээгдэх эрчим хүч (салхи, нар), эрчим хүчний хэмнэлт, тээвэр, усны тогтвортой менежмент, хог хаягдлыг бууруулах төслүүдийг санхүүжүүлдэг.

Зураг. Шилжилтийн санхүүжилтийн зураглал



Эх сурвалж: ICMA climate Transition Finance handbook

Цаашлаад, Ногоон/ТоХ–д чиглэсэн бонд нь бонд гаргагчид болон хөрөнгө оруулагчдын аль алинд нь хэд хэдэн давуу талуудыг бий олгодог. Тухайлбал, Хөрөнгө оруулагчдын хувьд орлогын менежментийн ил тод байдлыг хянах, тогтвортой байдлын чиглэлд хөрөнгө оруулах боломжийг олгодог бол бонд гаргагчдын

хувьд хөрөнгө оруулагчдыг төрөлжүүлэх, шинэ хөрөнгө оруулагчдыг татах, байгууллагын нэр хүндийг дээшлүүлэх, нийгмийн хариуцлагыг санхүүжилтийн схемтэй холбох, нийцүүлэх боломжийг олгодог. Эмпирик нотолгоонд тулгуурлан мэдээлсэн зарим давуу талуудыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт. Ногоон/ ТоХ–д бондын давуу тал

Хөрөнгө оруулагч	Бонд гаргагч
Эрсдэлийн удирдлагыг сайжруулж, урт хугацааны санхүүгийн өгөөжийг нэмэгдүүлэх: Тогтвортой хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалтын хэрэгслийн гүйцэтгэл нь уламжлалт хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнтэй харьцуулахад өндөр байдаг. Тухайлбал, орлогын ашиглалт болон төслийн гүйцэтгэл өндөр байх бөгөөд тайлагнал нь ил тод байдаг. Энэ нь эрсдэлийг удирдах хэрэгсэл болдог.	Хөрөнгө оруулагчдыг төрөлжүүлэх: Хүлэмжийн хийг бууруулахад чиглэсэн байгаль орчинд ээлтэй бонд нь бонд гаргагчид бүс нутгийн болон бусад олон улс орны хөрөнгө оруулагчдаас хөрөнгө босгох боломжийг олгодог.
Уур амьсгалын эрсдэлийг шийдвэрлэх: Ногоон бонд нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийг бууруулахад тусалдаг. Тухайлбал, ногоон бонд нь эрсдэл багатай бөгөөд ногоон байгууламж гэх мэт уур амьсгалд ээлтэй төсөлд хөрөнгө оруулалт хийдэг.	Захиалга давж биелэх: Ногоон бондыг зах зээлд гаргах үед ихэнх тохиолдолд эрэлт нь нийлүүлэлтээс давдаг бөгөөд хөрөнгө оруулагчид ногоон бондоо зарах сонирхолгүй байдаг тул хоёрдогч зах зээлд ногоон бонд ерөнхийдөө “sticky” байдаг.
Хөрөнгө хуваарилалтын босго хэмжээ: Ногоон бондын хөрөнгө оруулалт нь байгууллагын хөрөнгө оруулагчдад багцын хөрөнгийн хуваарилалтын босгыг давах/хэтрүүлэх боломжийг олгодог.	Урт хугацааны хөрөнгө оруулалт: Ногоон бондод хөрөнгө оруулагчид ихэнхдээ урт хугацааны хөрөнгө оруулалт хийхийг эрэлхийлдэг. Энэ нь урт хугацааны хөрөнгө оруулалт/ санхүүжилт хайж буй дэд бүтцийн төслүүдэд томоохон тус болдог.
Нэр хүнд, баталгааг нэмэгдүүлэх: Албан ёсны сертификаттай ногоон бондын зах зээлийн хөгжил нь хөрөнгө оруулагчдад хөрөнгөө хуурамч ногоон хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хуваарилахгүй байх баталгааг өгдөг.	Нэр хүнд: Ногоон бонд гаргахтай холбоотой ил тод байдлыг нэмэгдүүлэх, түүнтэй холбогдох шаардлагууд нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээхэн татдаг. Ногоон сертификат нь бонд гаргагчийн нэр хүндийг хөрөнгийн зэх зээлд ихээхэн нэмэгдүүлдэг.
Нийгмийн хариуцлагын тогтолцоог санхүүжилтийн схемтэй уялдуулах: Зарим ногоон бондын дотоод эрсдэл, өгөөж нь ижил зэрэглэл бүхий ердийн бондтой ижил байх үед Хөрөнгө оруулагчид “зорилгод суурилсан хөрөнгө оруулалт”-ыг илүүд үздэг.	Олон улсын амлалтууд болон Үндэсний хөгжлийн хөтөлбөрт нийцүүлэх: Бонд гаргагч нь Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шинийг санаачлагч, манлайлагч гэдгээрээ олон улсад хүлээн зөвшөөрөгддөг.
Ногоон бонд нь хөрөнгө оруулагчдад хөрөнгөө уур амьсгалын өөрчлөлтийн шийдэлд чиглүүлэх боломжийг олгодог. Жишээ нь: Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн хөрөнгө оруулагчдын эвслийн гишүүд 22 их наяд ам.долларыг ногоон, уур амьсгалын өөрчлөлттэй хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулсан.	
Үндэсний хөгжлийн хөтөлбөр, Байгууллагын хөрөнгө оруулагчдын удирдлагын дүрэмд нийцсэн ногоон санхүүгийн салбарт шинийг санаачлагч гэдгээ зах зээлд, цаашлаад олон улсад таниулах.	

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Компанийн засаглалын тухай ойлголтын хүрээнд хараат бус гишүүн нь компанитай эдийн болон эдийн бус аливаа харилцаагүй бөгөөд гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүнд үл хамаарах, өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдоггүй төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн гишүүн юм.

Хөрөнгийн биржид бүртгүүлэх шаардлага

Хөрөнгийн биржүүдээс компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд хараат бус гишүүдтэй холбоотой шаардлагыг тавьдаг. Тухайлбал, Нью-Йоркийн хөрөнгийн бирж (NYSE) нь ТУЗ-ийн олонхыг хараат бус гишүүн бүрдүүлдэг байхыг шаарддаг бөгөөд биржүүдийн тодорхойлолтод дараах байдлаар тусгажээ. Жишээ нь:

NYSE : "Хараат бус гишүүн" гэдэг нь тухайн компанитай шууд хамааралтай эсхүл холбогдох этгээд бус, хамтран аливаа үйл ажиллагаа хэрэгжүүлдэггүй, хувьцаа эзэмшигч бус, компанитай аливаа төрлийн харилцаатай бусад этгээдийн ажилтан, хамаарал бүхий этгээд бус гэж ТУЗ-өөс хянан баталгаажуулсан хүнийг хэлнэ.

NASDAQ : "Хараат бус гишүүн" гэдэг нь компанийн гүйцэтгэх удирдлага, эсвэл ажилтан биш бөгөөд үүрэг хариуцлагаа хараат бусаар хэрэгжүүлэхэд саад болох нөхцөл байдал үүсэхгүй гэж ТУЗ-өөс үзсэн хүнийг хэлнэ.

Хэдийгээр NYSE болон NASDAQ ялгаатай тодорхойлсон боловч үндсэн санаа нь хараат бус гишүүн нь өөрийн удирдах болон бизнесийн холбоотой компанитай эдийн болон эдийн бус харилцаагүй байх шаардлагатай. "Эдийн болон эдийн бус харилцаа" гэдэг нь тухайн хараат бус гишүүн өөрийн хүлээсэн үүрэг, хариуцлагыг хараат бусаар хэрэгжүүлэхэд саад болж болзошгүй нөхцөл байдал юм.

Хараат бус гишүүн томилохын ашиг тус

ТУЗ-д хараат бус гишүүн томилогдох нь компанийн зохистой засаглалын гол түлхүүр болдог аж. Олонх нь хараат бус гишүүдээс бүрдсэн компанийн ТУЗ-ийг ердийн гишүүдээс бүрдсэн ТУЗ-тай харьцуулахад гүйцэтгэх удирдлагыг хянахад илүү тохиромжтой байдаг бөгөөд олон төрлийн мэргэжилтэй хараат бус гишүүдтэй байснаар өргөн хүрээний зөвлөгөө, мэдээлэлтэй байхаас гадна компанитай аливаа төрлийн материаллаг харилцаагүй байдаг тул удирдлагын багийн нөлөөнд автдаггүй байна.


Хараат бус гишүүнийг томилоход учирч болзошгүй эрсдэл

Хараат бус гишүүд олон байх нь ашигтай хэдий ч нөгөө талаар сул талууд мөн адил байдаг. Тухайлбал, мэдээллийн тэнцвэргүй байдлын эрсдэл үүсдэг бөгөөд удирдлагын багтай харьцуулахад хараат бус гишүүдэд тухайн компанийн талаарх мэдээлэл харьцангуй хомс. Тухайн гишүүнийг хараат бус гэж тодорхойлсон хэдий ч энэ нь бие даасан байдлаар ажиллана гэсэн үг биш бөгөөд компанийн удирдлагын баг өөртөө татан, уусгах магадлалтай байдаг. Түүнчлэн, хараат бус гишүүн нь үүрэг, хариуцлагаа үр дүнтэй хэрэгжүүлэхэд хангалттай хэмжээний ур чадвар, мэдлэггүй байж болно.

S&P (Standard and Poor's 500 буюу АНУ-ын хөрөнгийн биржид бүртгэлтэй тэргүүлэгч 500 компанийн үнэлгээний индекс)-д бүртгэлтэй компаниудын ТУЗ-ийн хараат бус байдал

Wall street сэтгүүлд дурдсанаар, дүрэм, журмын хүрээнд S&P-т бүртгэлтэй компаниудын ТУЗ-ийн гишүүдийн олох нь хараат бус байдаг бөгөөд эзлэх хувь дараах байдалтай байдаг.

Хараат бус гишүүдийн эзлэх хувь:



Дээрх график дээрх хар цэг нь ТУЗ нь 100 хувь хараат бус гишүүдээс бүрдсэн буюу McDonald's, Kraft Heinz, Transocean зэрэг компаниуд юм.

Харин ТУЗ-ийн 50 буюу түүнээс бага хувь нь хараат бус гишүүнээс бүрддэг компаниудад News Corp, Urban Outfitters, Expedia, Essex Property Trust, Kinder Morgan, Brown-Forman, Fidelity National Information Services, Diamond Offshore Drilling, Cablevision Systems хамаарч байна.

Эх сурвалж: www.corporatefinanceinstitute.com



ФИНТЕК БА РЕГТЕК

ШИЛДЭГ 10: ФИНТЕК ТӨВҮҮД

Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар та бүхэндээ санхүүгийн салбарыг урагшлуулахад хувь нэмэр оруулж буй тэргүүлэх байршлуудыг АНУ-ын зүүн болон баруун эргийн төвүүдээс эхлэн Европ, Ази, Латин Америк хүртэлх гол байршлуудыг онцолж байна. Энэхүү мэдээллийг Fin-tech magazine-аас эрхлэн гаргадаг ШИЛДЭГ 10 нийтлэлийн хүрээнд бэлтгэв.

10. СИНГАПУР

Хөрөнгө оруулалт: 2019–2022 онд финтек салбарт 34 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн

BNPL хэрэглэгчид: 2022 онд 1.1 сая i: Grab, Wise, Airwallex, Aspire




Сингапур нь Азийн шилдэг финтек төвүүдийн нэг болж байр сууриа бэхжүүлсэн бөгөөд 2023 оны Tech Cities Index-д дэлхийд дөрөвдүгээрт оржээ. Тус улс 2019–2022 оны хооронд финтек салбарт 34 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татсан нь Ази-Номхон далайн

бүс нутагт хамгийн өндөр үзүүлэлт юм. Сингапурын финтек салбар төрөл бүрийн чиглэлээр хөгжиж байгаа бөгөөд ялангуяа дижитал төлбөр болон криптовалютын салбарт хүчтэй өсөлт ажиглагдаж байна. 2022 онд "Одоо аваад, дараа нь төл" (BNPL) үйлчилгээг ашиглагчдын тоо 1.1 саяд хүрсэн.

9. СТОКХОЛМ

Хөрөнгө оруулалт: 2015–2020 онд финтек салбарт 759 хувийн өсөлт
BNPL хэрэглэгчид: Klarna 200,000 гаруй дотоодын BNPL хэрэглэгчтэй
Гол компаниуд: Klarna, norbloc, Bits Technology




Стокхолм нь Европ дахь тэргүүлэх финтек төвүүдийн нэг болох байр сууриа бэхжүүлж, Скандинавын орнуудад хийгдсэн финтек хөрөнгө оруулалтын 85 хувийг эзэлж байна. 2015–2020 оны хооронд финтек хөрөнгө оруулалт 759 хувиар өсөж, нийт хөрөнгө

оруулалтын хэмжээгээр Европт гуравдугаарт жагсжээ. Стокхолм нь 400 гаруй финтек компанитай бөгөөд Европын хамгийн өндөр үнэлгээтэй финтек компани болох Klarna-гийн төв байршдаг. Шведийн нийслэл нь чадварлаг ажиллах хүчнээрээ давуу талтай бөгөөд нийт ажиллах хүчний 18 хувь нь технологийн салбарт ажиллаж байгаа нь Лондон, Берлинээс илүү өндөр үзүүлэлт юм.

8. БАНГАЛОР

Хөрөнгө оруулалт: 2019–2021 онд 17 тэрбум ам.долларын санхүүжилт
BNPL хэрэглэгчид: 2024 онд Энэтхэгийн хэрэглэгчдийн 22 хувь нь тус үйлчилгээгээр бараа худалдан авсан

Гол компаниуд: Razorpay, Paytm, Groww



"Энэтхэгийн Цахиурын хөндий" гэж нэрлэгддэг Бангалор нь тус улсын финтек стартапуудын төв юм. 2022 онд тус хотод 89 финтек стартап хэлцэл хийгдсэн нь Дели, Мумбай зэрэг томоохон хотуудаас илүү олон хэлцэл хийгдэж, илүү их санхүүжилт татжээ. Бангалор нь Энэтхэгийн


өндөр өсөлттэй технологийн стартапууд хамгийн их төвлөрсөн бүсээрээ алдартай бөгөөд Зүүн Өмнөд Азид ч тэргүүлэгч байр суурь эзэлдэг. Financial Times-ийн Ази-Номхон далайн бүсийн "Өндөр өсөлттэй компаниуд" жагсаалтад Бангалорын 14 компани багтсан байна. Түүнчлэн тус хот нь шууд гадаадын хөрөнгө оруулалтыг татах гол төв бөгөөд зөвхөн 2019 оны 10 дугаар сараас 2021 оны 12 дугаар сар хүртэл стартапууд 17 тэрбум ам.долларын санхүүжилт татжээ.

7. БЕРЛИН

Хөрөнгө оруулалт: 2023 оны I улиралд Германы стартапуудад хийгдсэн хөрөнгө оруулалтын 41.6 хувийг бүрдүүлсэн

BNPL хэрэглэгчид: 2024 онд өмнөх оноос 14 хувиар өссөн

Гол компаниуд: N26, Raisin Bank, Solarisbank



Берлин нь Европын финтек салбарын хүчирхэг төв болж 2023 оны байдлаар 300 гаруй финтек компанитай болсон. 2023 оны I улиралд тус хотод Германы стартап хөрөнгө оруулалтын 41.6 хувийг татсан бөгөөд үүнд финтек салбар ихээхэн хувь нэмэр оруулжээ.

Берлинд Германы финтек долоон ганц эвэрт компанийн зургаагийн төв байрладаг бөгөөд тус улсад байгаа бүх финтек стартапуудын 38 хувь нь нийслэлд байрладаг. Зөвхөн 2021 оны эхний хагаст Берлинд байрладаг финтек компаниуд 1.6 тэрбум евро (1.8 тэрбум ам.доллар)-ын хөрөнгө оруулалт авсан байна. Хотын экосистем нь олон төрлийн чадварлаг ажиллах хүчнээрээ давуу талтай бөгөөд стартап ажилчдын 25–50 хувь нь олон улсын үндэстэнгүүдээс бүрддэг.

6. ПАРИС

Хөрөнгө оруулалт: 2023 онд Францын финтек компаниуд 1.05 тэрбум ам.доллар татсан
BNPL хэрэглэгчид: 2024 онд арилжаа өмнөх оноос 15 хувиар өссөн
Гол компаниуд: Qonto, Alan, Fly Wallet




Парис нь Европын тэргүүлэх финтек төвүүдийн нэг бөгөөд 2023 онд Францын финтек компаниуд 939 сая евро (1.05 тэрбум ам.доллар) татсан нь Европын Холбоонд босгосон хөрөнгийн 18 хувийг эзэлж байна. Парис хотод 1,000 гаруй финтек компани байрладаг

бөгөөд жил бүр зохион байгуулагддаг Paris Fintech Forum нь 40 орны 500 гаруй олон улсын оролцогчдыг татан оролцуулдаг нь тус хотын финтек салбарын нөлөө өсөн нэмэгдэж буйг харуулж байна.

5. САН-ПАУЛУ

Хөрөнгө оруулалт: 2021 онд Сан-Паулугийн стартапууд 9.43 тэрбум ам.доллар татсан *BNPL хэрэглэгчид:* 83 сая гаруй бразилчууд тус арилжаа хийсэн *Гол компаниуд:* Nubank, Ebanx, PagSeguro



Сан-Паулу нь санхүүгийн технологийн инновацийн томоохон төв болохоор төлөвшиж байна. Бразилд 1,000 гаруй финтек компани байгаагаас Сан-Паулу нь технологийн салбарт өсөн нэмэгдэж буй нөлөөллөөрөө Өмнөд Америкийн Цахиурын хороолол хэмээх нэрийг авсан.

Хотын финтек экосистем хөгжиж байгаа бөгөөд үүнд Бразилийн Финтекүүдийн Холбоо томоохон дэмжлэг үзүүлж байна.

4. ЛОС АНЖЕЛЕС

Хөрөнгө оруулалт: 2023 онд Лос Анжелесийн финтек компаниуд 1.2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татсан *BNPL хэрэглэгчид:* Лос Анжелес дахь хэрэглэгчдийн 45.4 хувь нь 25–34 настай. *Гол компаниуд:* Gusto, Synapse, Super



Лос Анжелес финтек салбарт өөрийн өвөрмөц байр суурийг бий болгож, олон төрлийн эдийн засаг болон бүтээлч ажиллах хүчээ ашиглан хөгжиж байна. Хотын финтек салбарт 2018 оноос хойш ажиллах хүч 23 хувиар өссөн нь улсын дунджаас өндөр байна. 2023 онд Лос

Анжелесийн финтек компаниуд 72 хэлцлээр дамжуулан 1.2 тэрбум ам.долларын санхүүжилт босгож, үүнд Dave-ийн 4 тэрбум ам.долларын SPAC нэгтгэл зэрэг чухал хэлцлүүд багтжээ. Хотод 250 гаруй финтек стартап үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэдгээр нь LA Cleantech Incubator-ийн Финтек хурдасгуур хөтөлбөрөөс дэмжлэг авдаг.

3. ЛОНДОН

Хөрөнгө оруулалт: 2022 онд Лондонд 10.2 тэрбум ам.долларын финтек хөрөнгө оруулалт татсан *BNPL хэрэглэгчид:* Лондонгийн оршин суугчдын 58.7 хувь нь үйлчилгээг ашигладаг *Гол компаниуд:* Revolut, Monzo, Starling Bank

Эх сурвалж: <https://fintechmagazine.com/top10/top-10-fintech-hubs>



Лондон нь дэлхийн финтек салбарын хүчирхэг төв болох байр сууриа бататгаж 2022 онд 7.8 тэрбум фунт стерлинг (10.2 тэрбум ам.доллар)-ын финтек хөрөнгө оруулалт татсан нь Нью Йорк, Сан Францискогийн үзүүлэлтээс давсан байна.

Лондон нь дэлхийн тэргүүлэх финтек төв болон хөгжиж 2,500 гаруй финтек компанийн төв болжээ. 2022 онд Лондонд байгуулагдсан 27 финтек ганц эвэрт компани 168 шинэ стартап байгуулсан байна. Хотын финтек экосистем нь Barclays Accelerator, Accenture-ийн FinTech Innovation Lab зэрэг 20 гаруй инкубаторуудаар дэмжигдэж байна.

2. НЬЮ ЙОРК

Хөрөнгө оруулалт: 2023 онд Нью Йоркийн финтек компаниуд 3.2 тэрбум ам.доллар татсан *BNPL хэрэглэгчид:* "Санхүүгийн хувьд эмзэг" хэрэглэгчдийн 60 хувь нь тус үйлчилгээг ашигладаг *Гол компаниуд:* Chainalysis, Alloy, Betterment



Нью Йорк хотын финтек экосистем хөгжиж, инноваци, хөрөнгө оруулалтын хувьд Цахиурын хөндийтэй өрсөлдөх хэмжээнд хүрсэн байна. 2023 онд Нью Йоркийн финтек компаниуд 159 хэлцлээр дамжуулан 3.2 тэрбум ам.

долларын санхүүжилт татсан нь АНУ-ын финтек хөрөнгө оруулалтын 15 хувийг эзэлж байна. Хотод 1,500 гаруй финтек стартап байрладаг бөгөөд Ramp, Chainalysis зэрэг алдартай ганд эвэрт компаниуд энд төвтэй. Финтекийн ажиллах хүчний 44 хувь нь уламжлалт санхүүгийн салбарт ажиллаж байсан туршлагатай. 14 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж буй New York FinTech Innovation Lab-аас нийтдээ 94 стартап төгссөн бөгөөд тэдгээр нь нийтдээ 2.7 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт босгосон байна.

1. САН ФРАНЦИСКО

Хөрөнгө оруулалт: 2023 онд финтек компаниуд 3.8 тэрбум ам.доллар татсан *BNPL хэрэглэгчид:* Сан Францискогийн 25–34 насныхны 43.8 хувь нь BNPL үйлчилгээг ашигладаг *Гол компаниуд:* Stripe, SoFi, Chime



Сан Франциско нь дэлхийн тэргүүлэх финтек төв юм. 2023 онд тус хотын финтек компаниуд 176 хэлцлээр 3.8 тэрбум ам.долларын санхүүжилт татсан нь түүнийг дэлхийд тэргүүлэх байр сууриа хадгалахад тусалжээ. Сан Франциско нь 600 гаруй финтек стартаптай жил

бүр FinovateSpring гэх мэт томоохон арга хэмжээнүүд зохион байгуулагдаж 1,200 гаруй нөлөө бүхий оролцогчдыг татдаг. Хотын финтек орчинд Stripe, Chime зэрэг амжилттай стартапуудыг хөгжүүлсэн Y Combinator, 500 Startups зэрэг акселераторууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөн тус хотын санхүүгийн дүүрэгт АНУ-ын топ 100 банкны 30-ын төв байрладаг тул финтек болон уламжлалт санхүүгийн салбарын хамтын ажиллагаанд онцгой нөхцөл бүрддэг.

СУДЛААЧИЙН ИНДЭР

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ: ОЛОН УЛСАД

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Д.Даваамаа, СЗХ, ЗЗСХГ-ын ахлах мэргэжилтэн,
davaamaa@frc.mn

УДИРТГАЛ

Гишүүдийнхээ эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлэх ардчилсан удирдлага, хамтын хяналт бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээдийг Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ) гэнэ (ХЗХтХ, 2012). ХЗХ болон бусад зээлийн байгууллагууд нь хугацаа хэтрэх эрсдэл, санхүүжилтийн хөрвөх чадварын эрсдэлтэй үргэлж тулгардаг бөгөөд санхүүгийн хямралд хүргэж болзошгүй чанаргүй зээл болон санхүүжилтийн эрсдэлийг байнга хянаж, удирдах шаардлагатай болдог.

Дэлхийн Зээлийн Хоршооны Холбооны Зөвлөл (WOCCU)–өөс ХЗХ–дод зохистой харьцааг тооцох PEARLS арга зүйг санал болгодог. Тус арга зүй нь 1986 онд Гватемал улс ХЗХ–дын үйл ажиллагаанд нэвтрүүлснээр ХЗХ–ны системийн эрсдэлийн асуудлууд шийдэгдэж үйл ажиллагаа нь тогтворжоноор олон улсын ХЗХ–дын хэрэглээнд нэвтэрч эхэлжээ. Харин 1979 онд АНУ–ын Холбооны Нөөцийн банк (Federal Reserve Bank)–аас арилжааны банкны санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийх, мөн газар дээр шалгалтаар байгууллагад үнэлгээ өгөх зорилгоор CAMEL арга зүйг ашиглаж эхэлсэн ба 1987 онд Америкийн Нэгдсэн Улсын Үндэсний зээлийн холбооны захиргаанаас ХЗХ–дод хэрэгжүүлж эхэлснээр олон улсын санхүүгийн байгууллагууд хүлээн зөвшөөрсөн хяналтын болон үнэлгээний систем болсон.

ХЗХ нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг дагаж мөрдөх нь гишүүдийн хадгаламжийн эрсдэлд өртөх магадлалыг бууруулах, үйл ажиллагаа нь тогтвортой урт хугацаанд явуулах, амьдрах чадварыг нэмэгдүүлэх давуу талуудтай. Улс орнуудын ХЗХ–д нь гол төлөв дээрх 2 арга зүйг ашиглан зохистой харьцааг тооцон дагаж мөрддөг.

Монгол Улсын хувьд PEARLS арга зүйг ашигладаг бөгөөд анхны “ХЗХ–ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн журам”–ыг 2008 онд анх баталсан ба түүнээс хойш 5 удаагийн өөрчлөлт оруулан хүчин төгөлдөр мөрдөж байна. 2024 оны II улирлын байдлаар ХЗХ–дын 24.9 хувь нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан бол 9.4 хувь нь 5 болон түүнээс дээш зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллаагүй байна. Ийнхүү эдгээр харьцааг мөрдөж ажиллаагүй тохиолдолд төлбөр түргэн гүйцэтгэх чадвар буурч санхүүгийн тогтвортой байдал алдагдах нөхцөл бүрдэн хадгаламж эзэмшигчдийг хохироох, үйл ажиллагаа тасалдах зэрэг эрсдэлүүд үүснэ. Иймд энэхүү судалгаагаар Өмнөд Солонгос, Тринидад Тобаго, Кени, Австрали, Ирланд зэрэг 5 улсын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон олон улсын PEARLS арга зүйг Монгол улсын ХЗХ–дод хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулан судаллаа.

Энэхүү судалгааны ажил нийт 4 бүлэгтэй. Хоёрдугаар бүлэгт ХЗХ–ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцох арга зүйн талаар танилцуулна. Судалгааны гуравдугаар бүлэгт харгалзан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн олон улсын туршлагын талаар тусгасан. Харин эцсийн дөрөвдүгээр бүлэгт дүгнэлт, зөвлөмжийг оруулав.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

1. PEARLS арга зүй

PEARLS нь 45 санхүүгийн харьцааг ашиглан ХЗХ-ны санхүүгийн гүйцэтгэл, эрүүл мэндийг хэмжих арга зүй юм. Тус хэрэгсэл нь байгууллагын санхүүгийн тайлангийн тоон мэдээлэлд тулгуурлан санхүүгийн асуудлыг богино хугацаанд илрүүлэхэд чиглэгдсэн бөгөөд хөгжиж буй орнуудын ХЗХ-дын санхүүгийн үзүүлэлтийг стандартчилж, бүх хоршоодын гүйцэтгэлийг үнэлж, хооронд нь харьцуулах боломжийг олгодог.

1986–1994 онд Гватемал улсад иргэний дайны дараа ХЗХ-дын зээлийн өрийн үлдэгдэл нэмэгдсэнээр төлбөрийн чадваргүй болж уналтад орсон. Дэлхийн зээлийн холбооны зөвлөл (WOCCU) нь Гватемалын Үндэсний зээлийн холбоотой хамтран зээлийн хоршоодод техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн хүрээнд ХЗХ-дын үйл ажиллагаанд PEARLS-ийн арга зүйг ашигласан. Ингэснээр ХЗХ-ны системийн асуудлууд шийдэгдэж үйл ажиллагаа нь тогтворжиж тус арга зүй ХЗХ-дын хэрэглээнд нэвтэрч эхэлжээ.

PEARLS нь Protection-хамгаалалт, Effective financial structure-үр өгөөжтэй санхүүгийн бүтэц, Asset quality-Хөрөнгийн чанар, Rates of return and cost-зардал өгөөжийн түвшин, Liquidity-хөрвөх чадвар, болон Sign of growth-өсөлтийн дохио гэсэн үгсийн эхний үсгийн товчлол юм. Мөн PEARLS арга зүйд дараах зорилтуудыг хангадаг:

Гүйцэтгэх удирдлагын хэрэгсэл: ХЗХ-ны үйл ажиллагаанд хяналт тавих нь PEARLS системийн хамгийн чухал хэрэглээ юм. Энэ нь асуудлыг энгийн байдлаар тодорхойлохоос гадна удирдлагын хэрэгсэл болж байгууллагын асуудал, дутагдлыг арилгах цаашлаад шийдлийг олоход тусалдаг.

Стандартчилгдсан үнэлгээний харьцаа ба томьёо: Стандартчилсан санхүүгийн харьцаа, томьёог бүх нийтээр нэгэн зэрэг ашиглах нь ХЗХ-дын үйл ажиллагааг үнэлэхэд ашиглах санхүүгийн нэг хэлийг бий болгодог.

Харьцуулах, зэрэглэл тогтоох: Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон PEARLS-ийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг хослуулан ашигласнаар ХЗХ-дыг харьцуулан зэрэглэл тогтоох боломж бүрддэг.

Хяналт тавих үйл ажиллагааг хөнгөвчлөх: PEARLS систем нь удирдлагын хэрэгсэл болохоос гадна зохицуулагч

байгууллагын хяналтын нэгжийн гол хэрэглүүр болдог. зохицуулагч байгууллага нь PEARLS-ийн санхүүгийн харьцааг ашиглан зээлийн хоршооны үйл ажиллагааны бүх гол гүйцэтгэлүүдэд сар, улирал бүрээр дүн шинжилгээ хийх боломжтой.

2. CAMELS арга зүй

CAMELS арга зүйг 1987 онд Үндэсний зээлийн холбооны захиргаанаас ХЗХ-дод хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү систем нь олон улсын санхүүгийн байгууллагууд хүлээн зөвшөөрсөн хяналтын болон үнэлгээний систем болсон. CAMELS нь Capital adequacy-хөрөнгийн үзүүлэлт, Asset quality-хөрөнгийн чанар, Management soundness-Удирдлагын тогтвортой байдал, Earnings and profitability-Орлого ба ашигт байдал, Liquidity and Sensitivity-хөрвөх чадвар ба мэдрэмтгий байдал гэсэн үгсийн эхний үсгийн товчлол ба Санхүүгийн байгууллагын гүйцэтгэлийн 6 бүрэлдэхүүн хэсгийг үнэлдэг хяналтын үнэлгээний систем юм. CAMELS аргачлал нь дараах 6 зорилготой:

- ХЗХ-дын хөрөнгийн хүрэлцээг (C) хянаж, үнэлгээ хийж, богино хугацаанд бий болох санхүүгийн хүндрэлийг хэрхэн зохицуулж байгааг тодорхойлох;
- Байгууллагуудын багц дахь хөрөнгийн янз бүрийн эрсдэлд өртөх боломжийг судлахын тулд хөрөнгө оруулалт, зээлийг онцолж хөрөнгийн чанарыг (A) үнэлж, хэмжих;
- Хүний нөөц, үйл явц, хяналт, аудит зэрэг засаглал, удирдлагын хяналтыг үнэлж, дүгнэх замаар институц/зээлийн хоршоодын удирдлагын (M) ерөнхий зөв, үр дүнтэй байдлыг шалгадаг;
- Зээлийн хоршоодын орлого, ашигт ажиллагааны хүрэлцээг (E) судалж, хангалттай хөрөнгийн баазыг бүрдүүлэх, өргөтгөлийг санхүүжүүлэх, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах замаар алдагдлыг шингээх чадварт анхаарлаа хандуулдаг;
- Хөрвөх чадвар (L)-ын байдал ба хүрэлцээ нь зээлийн хоршоодын одоогийн болон хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний хэрэгцээ, түүний дотор зээлийн эрэлт, хувьцааг эргүүлэн татах болон бусад зардлуудыг хангах чадамжийг шалгадаг;

- Зах зээлийн эрсдэлд мэдрэмтгий байдал (S) нь зээлийн хүү, валютын ханшийн гэнэтийн тохируулгад зээл, хадгаламжийн мэдрэмтгий байдлыг судалдаг.

Дээр дурдсанчлан CAMELS үнэлгээг 1–5 хүртэлх оноогоор дүгнэдэг. 1 эсвэл 2 гэсэн үнэлгээ нь зээлийн хоршоод хяналт

ОЛОН УЛСЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ӨМНӨД СОЛОНГОС

Өмнөд Солонгос улсын хувьд Санхүүгийн байгууллагуудыг банк, банк бус санхүүгийн байгууллага (ББСБ), санхүүгийн хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэгч, даатгалын компани гэсэн дөрвөн төрөлд ангилдаг. ХЗХ нь ББСБ гэсэн ангилалд багтдаг бөгөөд ХЗХ–г зээлийн хоршоо, хөдөө аж ахуй, загас, ойн аж ахуйн хоршоо, олон нийтийн ХЗХ хэмээн ангилдаг. Үүнээс олон нийтийн ХЗХ нь Дотоод хэргийн яам болон Аюулгүй байдлын яамны хяналтад байдаг бөгөөд бусад нь Санхүүгийн хяналтын албаны хяналтад байдаг.

Санхүүгийн хяналтын алба нь ББСБ–уудад үнэлгээ хийж зэрэглэл тогтоохдоо CAMELS арга зүйг ашиглан хөрөнгийн хүрэлцээ, активын чанар, удирдлага, ашиг орлого, хөрвөх чадвар гэсэн 5 бүрэлдэхүүн хэсэгт дүн шинжилгээ хийж, хянан шалгалт хийдэг. ББСБ–уудад нийтлэг 6 зохистой харьцаа тавьж байна (FSS handbook, 2021). Үүнд:

1. Өөрийн хөрөнгийн харьцаа;
2. Хөрвөх чадварын харьцаа (дотоод болон гадаад мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн);
3. Зээл, хадгаламжийн харьцаа;
4. Чанаргүй зээлийн харьцаа;
5. Зээлийн алдагдал ба нөөцийн харьцаа;
6. Зээлийн хэмжээг сунгах дээд хязгаар.

ББСБ–уудад тавигдаж буй зохистой харьцааны үзүүлэлтийг хүснэгт 1–т харуулав. Үүнээс харахад ББСБ–д тавигдаж буй харьцаа нь үйлчилгээний онцлогоос хамааруулан өөр өөр байна. Тухайлбал, минимум капиталын харьцаа нь дундын хадгаламжийн банканд 7 хувиас багагүй, мерчант банкнууд болон зээлийн үйлчилгээний компаниудад 8 хувиас багагүй байхаар тусгагдсан бол ХЗХ–ны хувьд цэвэр хөрөнгийн харьцаагаар илэрхийлэгдсэн байна. Энэхүү харьцаа нь хамгийн багадаа 2 хувь байна.

шалгалтын асуудал багатай гэж илэрхийлдэг бөгөөд энэ нь тогтвортой үйл ажиллагааг хангадаг эрсдэлийн удирдлагын практик, хангалттай гүйцэтгэлийг харуулж байна. Үүний эсрэгээр 3, 4, 5 гэсэн үнэлгээ нь тус ХЗХ нь дунд зэргийн болон хэт өндөр эрсдэлтэй, хангалтгүй муу гүйцэтгэлийг илтгэнэ.

Түүнчлэн, ХЗХ–ны үйл ажиллагаанд хөрвөх чадварын болон чанаргүй зээлийн харьцаа тогтоогоогүй бол зээл–хадгаламжийн харьцааг 100 хувь, зээлийн алдагдал ба нөөцийн харьцааг 100 хувь байхаар мөрдөж ажиллах ёстой. Цаашлаад, ХЗХ–ны хувьд нэг гишүүнд олгох зээлийн хэмжээ нь өөрийн хөрөнгийн 20 хувь, эсхүл нийт хөрөнгийн 1 хувиас хэтрэхгүй байна гэсэн ерөнхий шалгуур тавьдаг ч зээлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь тухайн тохиолдлоос хамааран өөр өөр байдаг. Тухайлбал, өөрийн хөрөнгийн 20 хувьтай тэнцэхүйц мөнгөн дүн нь нийт хөрөнгийн 1 хувиас их байвал зээл олгох дээд хэмжээг 5–10 тэрбум вон хүртэл нэмэгдүүлж болно. Эсрэг тохиолдолд зээл олгох дээд хэмжээ 700 сая воноор хязгаарлагддаг. Харин гол төлөв өрхийн хэрэглээний зээл олгодог бол ХЗХ нь зээл олгох дээд хэмжээг нэмэгдүүлэх эрхгүй ба бүх ХЗХ–дын нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн дээд хэмжээнд хязгаарлалт тавьдаггүй байна.

Мөн ХЗХ нь гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн 10–аас доошгүй хувийг заавал байлгах нөөцөд, 50–иас доошгүй хувийг Үндэсний холбооны дансанд байршуулж, үлдсэнийг нь бэлэн мөнгө, бусад санхүүгийн байгууллагуудад хадгаламж хэлбэрээр байршуулсан байх ёстой.

ТРИНИДАД ТОБАГО

Тринидад Тобаго улсын ХЗХ–ны тухай хууль нь 2009 онд батлагдсан бөгөөд тус хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллага нь Төв банк юм. Төв банкны зүгээс ХЗХ–ны эрх зүйн орчныг бүрдүүлэх, сайжруулах санал боловсруулахдаа Дэлхийн зээлийн хоршооны холбооны зөвлөлөөс тогтоосон олон улсын стандартууд болон зээлийн хоршоодын салбар хөгжсөн улс орнуудын сайн туршлагыг харгалзан үзэж өөрийн орны онцлогт тохируулан буулгадаг бөгөөд ХЗХ–ны санхүүгийн гүйцэтгэлийг үнэлэх, зэрэглэл тогтоохдоо PEARLS–ийн арга зүйг ашигладаг.

ХЗХ–ны тухай хуульд заасны дагуу ХЗХ–ны хоршоологчдын өмчийн нийт хөрөнгөд эзлэх хувь нь 8 хувиас багагүй байх

ба хэрэв ХЗХ тус зохистой харьцааг хангаагүй тохиолдолд гишүүдэд ногдол ашиг олгохыг хязгаарладаг. Мөн ХЗХ-ны үл хөдлөх хөрөнгийн эзэмшлийн хэмжээг бизнес эрхлэхэд шаардлагатай үл хөдлөх хөрөнгө, ажилчдыг орон сууцжуулахаас бусад тохиолдолд нийт хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй байхаар тогтоосон.

Харин төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хувьд нийт өр төлбөрт эзлэх хөрвөх чадвартай хөрөнгийн хувийг хамгийн багадаа 15 хувь байхаар хадгалах шаардлагатай бол нийт зардалд эзлэх үйл ажиллагааны зардлыг нийт хөрөнгийн 5 хувиар хязгаарлах ёстой.

ХЗХ-ны чанаргүй зээлийн дээд хэмжээ нийт зээлийн багцын 4.5 хувиас хэтрэхгүй харин тус байгууллагын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл болон төсөл, хөтөлбөрийн зээл нь нийт хөрөнгийн 8 хувиас хэтрэхгүй байна. Нийт хөрөнгөд эзлэх хоршоологчдын өмчийн 12 хувийг хангаж буй тохиолдолд энэхүү хязгаарыг 10 хувь хүртэл нэмэгдүүлэх боломжтой.

ХЗХ-ны аливаа нэг байгууллага, хувь гишүүн, эсвэл нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн дээд хэмжээ нь өөрийн хөрөнгийн 25 хувиас хэтрэхгүй байна.

ХЗХ нь хугацаа хэтэрсэн зээлийг цаг тухайд нь тодорхойлж, зээлийн боломжит алдагдлыг нөхөх хангалттай ерөнхий эрсдэлийн санг байгуулах үүрэгтэй. Уг сан нь зээлийн багцын үнийн дүнгийн 0.5–4.5 хувьтай тэнцэхүйц байна. Төв банкнаас зээлийн эх үүсвэрийг бүхэлд нь эсхүл аль нэг хэсэгт нь хэсэгчлэн нөхөх дараах санг байгуулахыг шаардаж болно:

- Хэвийн бус зээлийн 20 хувь;
- Эргэлзээтэй зээлийн 50 хувь;
- Муу зээлийн 100 хувь.

Цаашлаад зээл нь “чанаргүй” ангилалд багтсан хэдий ч үл хөдлөх хөрөнгөөр бүрэн баталгаажсан, түүнийг хураах шатандаа байгаа эсхүл бэлэн мөнгө, хувьцаагаар зуун хувь баталгаажсан тохиолдолд ямар нэгэн эрсдэлийн сан үүсгэх шаардлагагүй.

Тринидад Тобаго улсын Төв банкнаас хадгаламжийн нийт хөрөнгөд эзлэх хувь, зээлийн зохистой харьцаа, нөөц сан болон хадгаламж хамгаалалтын сангийн хоршоологчдын өмчид эзлэх хувь, нэг гишүүний оруулсан хувь хөрөнгийн хэмжээнд зохистой харьцаа тогтоогоогүй байна. Гэсэн хэдий ч ХЗХ нь жил бүр цэвэр ашгийн 20 хувийг нөөц санд байршуулах ба хадгаламж хамгаалалтын санд байршуулах мөнгөн дүнг

өөрийн дотоод дүрмээр зохицуулах, мөн нийт гишүүдийн оруулсан хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг гишүүдийн мэдээллийг Төв банканд мэдээлэх үүрэгтэй.

КЕНИ

Кени улсын ХЗХ-г ХЗХ-ны нийгэмлэгийг зохицуулах газар (The Sacco Societies Regulatory Authority) зохицуулдаг. Тус зохицуулагч байгууллага нь 2008 онд батлагдсан ХЗХ-ны нийгэмлэгийн тухай хуулийн дагуу гишүүдээсээ хадгаламж татан төвлөрүүлэх, зээл олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тэдгээр үйл ажиллагааг зохицуулах, хянан шалгалт хийх, ХЗХ-оос цуглуулсан зохицуулалтын үйл ажиллагааны төлбөрийг эзэмших, захиран зарцуулах, ашиглах, шимтгэл хураах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.

ХЗХ-ны нийгэмлэгийн тухай хуулийн дагуу ХЗХ-ны хөрөнгө нь дараах зохистой харьцааны шалгуурыг хангасан байх ёстой:

- Үндсэн хөрөнгийн хэмжээ 10 сая шиллингээс багагүй;
- Үндсэн хөрөнгө нь нийт хөрөнгийн 10 хувиас багагүй байна. Үүнээс газар, барилга байгууламж 5 хувиас хэтрэхгүй;
- Хоршоологчдын өмч нь нийт хөрөнгийн 8 хувиас багагүй;
- Үндсэн хөрөнгө нь хадгаламжийн 8 хувиас багагүй байна.

Мөн тус улсын ХЗХ-дын дагаж мөрдөх төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа 15 хувь бөгөөд энэхүү зохистой харьцааг хадгалахын тулд ХЗХ-ны Тэргүүлэгчдийн зөвлөл нь жил бүр хөрвөх чадварын удирдлагыг хариуцах болон зээлийн шугамд хандах албан тушаалтныг томилдог, мөн нийт мөнгөн хөрөнгийн доод ба дээд хязгаар, бэлэн мөнгө эзэмших хязгаар, хөрөнгийн болон хөрвөх чадварын удирдлагын хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх заавар, хөрөнгө, хөрвөх чадварын байдалд дүн шинжилгээ хийх давтамж зэргийг багтаасан бодлогын баримт бичгийг боловсруулах, түүнд хяналт тавьж ажиллах үүргийг хүлээдэг. Тэргүүлэгчдийн зөвлөл нь хөрвөх чадварын алдагдлыг шийдвэрлэх онцгой байдлын төлөвлөгөөг баталдаг. Төлөвлөгөөнд онцгой байдлын үед хөрвөх чадварын дутагдлыг нөхөх, санхүүжилтийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан нөхцөлд хөрвөх чадварыг нөхөх стратегийг тусгасан байх ёстой.

Зохицуулагч байгууллага холбогдох чөлөөлөлт хийх эрх олгоогүй тохиолдолд ХЗХ–ны банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, төсөл, хөтөлбөрийн зээл нь нийт хөрөнгийн 25 хувиас хэтрэхгүй байх ёстой. Харин бусдаас авсан зээл дээрх хязгаарлалтаас хэтрэх тохиолдолд зохистой харьцааны үзүүлэлтийн дээд хязгаарыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулсан нарийвчилсан тайлбарыг агуулсан баримт бичгийг өргөдлийн хамт зохицуулагч байгууллагад хүргүүлнэ. Хэрэв ХЗХ–оос санал болгож буй зээлийн хязгаар нь тус байгууллагын үйл ажиллагаанд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй хэмээн зохицуулагч байгууллага үзсэн тохиолдолд тус хязгаарыг нэмэгдүүлэх эрхийг олгодог.

Гишүүддээ зээл олгох зорилгоор гаднын байгууллагаас зээл авч байгаа ХЗХ нь уг гаднын зээлд төлөх хүүгээс дор хаяж 2 хувиар өндөр хүүгээр гишүүддээ зээл олгох ба ХЗХ–ны нэг гишүүнд олгох зээлийн хэмжээ нь үндсэн хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй байна.

- Мөн ХЗХ нь зээлийг дараах байдлаар ангилах ба зээлийн эрсдэлийн санг байгуулна:
- Хэвийн зээлийн 1 хувь;
- Хугацаа хэтэрсэн зээлийн 5 хувь;
- Хэвийн бус зээлийн 25 хувь;
- Эргэлзээтэй зээлийн 50 хувь;
- Муу зээл 100 хувь.

Түүнчлэн, Кени улсын ХЗХ–дын зохицуулагч байгууллага нь чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, хадгаламжийн нийт хөрөнгөд эзлэх хувь, нийт зардалд эзлэх үйл ажиллагааны зардлын хувь, нөөц сан болон хадгаламж хамгаалалтын сангийн хоршоологчдын өмчид эзлэх хувь, нэг гишүүний оруулсан хувь хөрөнгийн хэмжээнд зохистой харьцаа тогтоогоогүй байна. Хэдийгээр дээр дурдсан үзүүлэлтүүдэд зохистой харьцаа тогтоогоогүй ч ХЗХ нь жил бүр цэвэр ашгийн 20 хувийг нөөц санд байршуулах, мөн нийт гишүүдийн оруулсан хөрөнгийн 10 хувь, хадгаламжийн 20 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг гишүүдийн мэдээллийг Төв банканд мэдээлэх үүрэгтэй. Цаашлаад, Сангийн сайдын баталсан журмын дагуу хадгаламжийн батлан даалтын санд жил бүр 50,000 шиллинг эсхүл нийт хадгаламжийн 0.175 хувьтай тэнцэх хэмжээний шимтгэл хоёрын аль өндрийг төлдөг. Хадгаламжийн батлан даалтын сан нь ХЗХ–дын гишүүн бүрийн хувьд 100,000 шиллинг хүртэлх хэмжээний хадгаламжийг эрсдэлээс хамгаалах чадамжтай.

АВСТРАЛИ

Австрали Улсын хадгаламжийн байгууллагууд, даатгал болон тэтгэврийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий байгууллага нь Австралийн зохистой байдлын зохицуулалтын газар (Australian Prudential Regulation Authority) юм. Австрали улсын Төв банкны тухай хуульд тодорхойлсны дагуу Хадгаламжийн Байгууллага (ADI) гэдэг нь Зохицуулах байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр олон нийтээс хадгаламж татах эрх бүхий санхүүгийн байгууллага юм.

Австралийн зохистой байдлын зохицуулалтын газрын хяналтад байдаг хадгаламжийн байгууллагууд нь нэгэн ижил зохистой харьцааг дагаж мөрддөг. Тухайлбал өөрийн хөрөнгийн доод хэмжээ нь хадгаламжийн 8 хувь, харин төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа хамгийн багадаа 9 хувь байна. Түүнчлэн ХЗХ–ны нэг гишүүн болон нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцааг ХЗХ–ны зээлийн бодлогын баримт бичигт тусган дагаж мөрддөг байхаар хуульчилсан. Мөн нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгө 20 хувиас хэтрэхгүй бөгөөд нөөц сангийн хэмжээг хамгийн багадаа хоршоологчдын өмчийн 2.5 хувьтай тэнцүү байхаар тогтоожээ.

Хадгаламж хамгааллын сангийн хувьд 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын оргил үед Австрали Улс нь хэрэглэгчдийн хадгаламжийг хамгаалах нэмэлт давхарга буюу Санхүүгийн нэхэмжлэлийн схем (Financial Claims Scheme)–ийг бий болгосон. Санхүүгийн нэхэмжлэлийн схем нь банк, ХЗХ, барилгын нийгэмлэг зэрэг Австралийн хадгаламж хүлээн авах эрх бүхий байгууллагын хадгаламж эзэмшигчид болон ердийн даатгалд даатгуулагчдын хувьд нэмэлт хамгаалалт төдийгүй хадгаламж, нөхөн төлбөрийг шуурхай авах боломжийг олгодог. Санхүүгийн нэхэмжлэлийн схем нь хадгаламжийн байгууллагын данс эзэмшигч бүрийн 250,000 ам.доллар хүртэлх хадгаламжийг хамгаалах засгийн газрын дэмжлэгтэй хамгаалалтын схем юм. Тус схем нь ердийн даатгалын хувьд 5,000 ам.доллар хүртэлх нөхөн төлбөрийг авах боломжтой ба тодорхой шалгуурыг хангасан тохиолдолд 5,000 ам.доллороос дээш нөхөн төлбөр авах боломжтой. Хадгаламжийн байгууллага эсвэл Ердийн даатгалын компани үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд Засгийн газар үүрэг болгосны дагуу Австралийн зохистой байдлын зохицуулалтын газар нь Санхүүгийн нэхэмжлэлийн схемийг идэвхжүүлэх эрхтэй. Энэ нь Австрали доллараар хадгалагдаж буй гүйлгээ, хадгаламж, чекийн данс, хугацаатай хадгаламж, ипотекийн офсет данс зэрэг өргөн хүрээний данснуудыг хамруулдаг.

ИРЛАНД

Ирланд Улсын ХЗХ–ны тухай хууль 1966 онд анх батлагдаж, 1997, 2013, 2015, 2016, 2018 онуудад өөрчлөлт орсон ба тус хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллага нь Төв банк юм. 2018 оны ХЗХ–ны гарын авлага–д дурдсанаар Төв банкнаас дараах зохистой харьцааг ХЗХ–д үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахаар тогтоосон:

- Нэг гишүүнд олгох зээлийн зохистой харьцаа;
- Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа;
- Хадгаламжийн зохистой харьцаа;
- Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа;
- Нөөцийн сангийн хэмжээ;
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа.

ХЗХ–ны тухай хуульд заасны дагуу ХЗХ нь хэрэглээний зээл, бизнесийн зээл, нийтийн зээл, орон сууцны зээл болон бусад ХЗХ–дод зээл олгох эрхтэй. ХЗХ–ны нэг гишүүнд (хувь хүн) олгох зээлийн дээд хэмжээ зохицуулалттай нөөцийн 2.5 хувиас хэтрэхгүй ба нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн дээд хэмжээ зохицуулалттай нөөц–ийн 10 хувь эсхүл 39,000 еврогоос хэтрэхгүй байна. Цаашлаад орон сууцны зээл, бизнесийн зээлийн хувьд тус зээлийн өрийн үлдэгдэл нийт хөрөнгийн 7.5 хувиас хэтрэхгүй. Хэрэв ХЗХ нь тодорхой

шаардлагыг хангасан тохиолдолд орон сууцны зээл болон бизнесийн зээлтэй холбоотой нийт өрийн үлдэгдлээ зээлийн хоршооны хөрөнгийн 10 болон 15 хувь хүртэл нэмэгдүүлэх боломжтой. Ийнхүү хязгаарыг 10 хувь хүртэл нэмэгдүүлэх тохиолдолд тухайн ХЗХ нь сүүлийн 2 улирал дараалан хамгийн багадаа 50 сая еврогийн нийт актив, нийт хөрөнгөд эзлэх зохицуулалтын нөөц нь 12.5 хувиас багагүй байна. Харин 15 хувь хүртэл нэмэгдүүлэх тохиолдолд сүүлийн 2 улирал дараалан хамгийн багадаа 100 сая еврогийн нийт хөрөнгөтэй байх шаардлагыг хангасан байх шаардлагатай. Мөн зээлийн дээд хязгаарыг нэмэгдүүлэх тухай мэдэгдлээ бичгээр гаргаж холбогдох шаардлагыг хангаж байгааг нотолсон баримт бичгийн хамт 30 хоногийн өмнө Төв банканд хүргүүлнэ.

Харин хадгаламжийн зохистой харьцааны хувьд ХЗХ–ны нэг гишүүн хамгийн ихдээ 100,000 еврогийн хадгаламжтай байна. ХЗХ нь гишүүн бүрийнхээ нийт хадгаламжийг тооцож 100,000 еврогоос бага байгааг баталгаажуулах үүрэгтэй бөгөөд ингэхдээ гишүүн бүрийн бүх төрлийн дансанд байгаа хадгаламжийг харгалзан үзнэ. Энэ нь гишүүн бүрийн эзэмшдэг дансны тооноос үл хамааран нийт 100,000 хүртэлх еврогийн хадгаламж эзэмших боломжтой гэсэн үг юм.

ХЗХ–ны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа нь хадгаламжийн 20 хувиас багагүй байна. Нэг зээлдэгч гишүүн нь нийт хадгаламжийн 25 хувиас ихгүй мөнгөн дүн бүхий зээлийг барьцаагаар болон бусад хэлбэрээр авч болно.

ДУГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаар Өмнөд Солонгос, Тринидад Тобаго, Кени, Австрали, Ирланд зэрэг 5 улсын ХЗХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн зохицуулалтын туршлагыг судаллаа. Эдгээр улс орнуудын харьцааны шалгуур үзүүлэлтийн туршлагаас харахад Өмнөд Солонгос, Тринидад Тобаго, Ирланд улсын хувьд үндсэн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх зохистой харьцааг 5–10 хувиас хэтрэхгүй байхаар, Кени улсын хувьд тус зохистой харьцааг 10 сая шиллингээс багагүй байх мөнгөн дүнгээр тогтоодог бол Австрали улс тус харьцаанд шалгуур үзүүлэлт тогтоогоогүй байна. Харин төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа нь тус улс орнуудын хувьд хамгийн багадаа 9–20 хувь байхаар тогтоогджээ.

Нэг гишүүнд олгох зээлийн дээд хязгаарыг Кени улс 10 хувиас, Тринидад Тобаго улс 25 хувиас тус тус хэтрэхгүй байхаар, Австрали улс нь ХЗХ өөрийнхөө зээлийн бодлогын баримт бичигт тусгаж мөрдүүлэхээр зохицуулсан бол Өмнөд Солонгос улсын хувьд ХЗХ-ны хувьд нэг гишүүнд олгох зээлийн хэмжээ нь өөрийн хөрөнгийн 20 хувь, эсхүл нийт хөрөнгийн 1 хувиас хэтрэхгүй байна. Харин Тринидад Тобаго улсын хувьд бусдаас авсан зээлийн зохистой харьцааг шатлалтай тогтоосон бол Ирланд улс нь орон сууцны зээл олгох зээлийн дээд хязгаарыг шатлалтай тогтоожээ. Тухайлбал, ХЗХ-ны банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл болон төсөл, хөтөлбөрийн зээл нийт хөрөнгийн 8 хувиас хэтрэхгүй байх ёстой хэдий ч нийт хөрөнгөд эзлэх хоршоологчдын өмчийн 12 хувийг хангаж буй тохиолдолд энэхүү хязгаарыг 10 хувь хүртэл нэмэгдүүлэх боломжтой.

Цаашлаад, Зарим улс орнуудад чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, зээлийн зохистой харьцаа, хадгаламжийн нийт хөрөнгөд эзлэх хувь, нийт хөрөнгөд эзлэх үйл ажиллагааны зардлын хувь, нөөц сан болон хадгаламж хамгааллын сан, нэг гишүүний оруулсан хувь хөрөнгийн хэмжээнд зохистой харьцаа тогтоогоогүй байна. Хэдийгээр дээр дурдсан үзүүлэлтүүдэд зохистой харьцаа тогтоогоогүй ч ХЗХ нь жил бүр цэвэр ашгийн 10–20 хувийг нөөц санд байршуулах, мөн нийт гишүүдийн оруулсан хөрөнгийн 10 эсхүл 20 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг гишүүдийн мэдээллийг Зохицуулагч байгууллагад мэдээлдэг. Ийнхүү олон улсын туршлагаас харахад улс орнуудын зохистой харьцааг тогтоосон байдал нь тухайн улсын санхүүгийн зах зээлийн бүтэц онцлогоос хамааран өөр өөр байна.

Иймд олон улсын туршлагад үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна:

- Дэлхийн зээлийн холбоодын зөвлөлөөс Хадгаламж болон зээлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 70–80 хувь байлгахыг зөвлөдөг тул Монгол Улсад одоо мөрдөгдөж зохистой харьцааны хувь хэмжээг нийцүүлэх;
- Улс орнууд үйл ажиллагааны зардлын нийт хөрөнгөд эзлэх хувийг 5 хувиас хэтрэхгүй байхаар тогтоосон ба Монгол Улсын ХЗХ-дын дагаж мөрдөж буй тус харьцаа нь 15 хувь буюу бусад улс орнууд болон Дэлхийн зээлийн холбоодын зөвлөлөөс санал болгосон харьцаанаас 3 дахин өндөр байгаа нь ХЗХ-дыг үйл ажиллагааны өндөр зардал гаргах, цэвэр ашгийн хэмжээ буурах нөхцөлд хүргэж болзошгүй. Иймд тус харьцааг олон улсын стандартад нийцүүлэн өөрчлөх боломжийг судлан үе шаттайгаар бууруулах;
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тооцох аргачлалыг PEARLS стандартад нийцүүлэх;
- Олон улсын туршлага, Монгол Улсын нөхцөлд тулгуурлан нэг гишүүний хадгаламжид зохистой харьцаа тогтоох талаар бодлогын арга хэмжээ авах;
- Олон улсын туршлагад үндэслэн ХЗХ тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд зарим зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн харьцааг нэмэгдүүлэх талаар бодлогын арга хэмжээ авах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. APRA, 2009, Financial Claims Scheme. Available at: <https://www.apra.gov.au/financial-claims-scheme-0>
2. Sian Murray et al., 2021, "Regulatory Capital for Irish Credit Unions: Time for Change?", Available at: https://cuceoforum.ie/wp-content/uploads/2021/06/CEO-Forum-Regulatory-Capital-for-Irish-Credit-Unions-v1_0.pdf
3. ICURN, 2019, "Central Bank of Ireland's Performance of its Regulatory Functions in Relation to Credit Unions", Available at: <https://www.centralbank.ie/docs/default-source/regulation/industry-market-sectors/credit-unions/communications/reports/icurn-peer-review-report.pdf>
4. ARPA, 2018, "Regulations for Credit Unions", Ireland
5. the National Council, 2022, The SACCO Societies Act, Available at:
<http://kenyalaw.org:8181/exist/rest//db/kenyalex/Kenya/Legislation/English/Acts%20and%20Regulations/S/Sacco%20Societies%20Act%20-%20No.%2014%20of%202008/docs/SaccoSocietiesAct14of2008.pdf>
1. Law Society of Kenya SACCA society ltd, 2019, Member share capital (increment) information. Available at: <https://lksacco.co.ke/wp-content/uploads/2020/01/LKSACCO-MEMBER-SHARE-CAPITAL-INCREAMENT-INFORMATION-DOC-January-2020-1.pdf>
2. WOCCU, 2008, Technical Guide Credit Union Regulation and Supervision. Available at: <https://www.findevgateway.org/sites/default/files/publications/files/mfg-en-toolkit-credit-union-regulation-and-supervision-technical-guide-2008.pdf>
3. Financial Supervisory Service, 2021, FSS handbook. Available at: <https://www.bing.com/ck/a?!&p=37c-798d3cb8d8ba9JmltdHM9MTcxNzExMzYwMCZpZ3VpZD0xZTFjNjk1Ni1kNWl1LTU1MDUtMDQ1My03YT-cyZDRkNTY0ZWEmaw5zaWQ9NTlyOA&ptn=3&ver=2&hsh=3&fclid=1e1c6956-d5b5-6505-0453-7a72d4d564ea&p-sq=FSS+handbook&u=a1aHR0cHM6Ly9lbmdsaXNoLmZscy5vci5rci9lbmcvY21bi9maWxlL2ZpbGVeb3duLmRvP-2F0Y2hGaWxISWQ9ZjMxNjA0YTQzMzMzNDM3YTljYzI5MjBmMzFjNzViMzYmZmlsZVNuPTE&ntb=1>
4. Seung Yong Ahn, 2018, Korean Credit Unions CSR and Social Finance. Available at: <https://www.bing.com/ck/a?!&p=77375b05cd2f222bJmltdHM9MTcxNzExMzYwMCZpZ3VpZD0xZTFjNjk1Ni1kNWl1LTU1MDUtMDQ1My03YT-cyZDRkNTY0ZWEmaw5zaWQ9NTE5OA&ptn=3&ver=2&hsh=3&fclid=1e1c6956-d5b5-6505-0453-7a72d-4d564ea&psq=Korean+Credit+Unions+CSR+and+Social+Finance&u=a1aHR0cHM6Ly93d3cuaXJ1LmRIL3dwLWNvbn-RlbnQvdXBsb2Fkcy8yMDIwLzA2L1JhaWZmZWlzcW5Ub2RheV9DaGFwdGVyMTRfU291dGgtS29yZWEucGRm&ntb=1>
5. Laws of Trinidad and Tobago, 2015, Co-Operative Societies Act. Available at: <https://www.bing.com/ck/a?!&p=9710a4dfacf2145fJmltdHM9MTcxNzExMzYwMCZpZ3VpZD0xZTFjNjk1Ni1kNWl1LTU1MDUtMDQ1My03YT-cyZDRkNTY0ZWEmaw5zaWQ9NTlxNQ&ptn=3&ver=2&hsh=3&fclid=1e1c6956-d5b5-6505-0453-7a72d4d564ea&p-sq=Co-Operative+Societies+Act&u=a1aHR0cDovL3d3dy5rZW55YXhdy5vcmcva2wwZmlsZWZfbWUuL3BkZmRvd25sb-2Fkcy9BY3RzL0NvLW9wZXJhdGIlZ2VNVy2IldGllc0FjdENhcDQ5MC5wZGY&ntb=1>
6. Central Bank of Trinidad and Tobago, 2009, The policy proposal document for the Credit Union Act.
7. Санхүүгийн зохицуулах хороо (2024), ХЗХ-дын 2024 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга. Эх үүсвэр:
<http://www.frc.mn/resources/Images/Document/202402/0FnCx/SCC-netgtel-2023.IV---Huraangui.pdf>

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГИШҮҮНЧЛЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?



20-оос доошгүй гишүүнтэй байна.



10-аас дээшгүй хувь нь хуулийн этгээд байж болно.



Эрх зүйн бүрэн чадамж бүхий Монгол Улсын иргэн, хуулийн этгээд.



Гэр бүл, төрөл садангийн хүмүүс гишүүнээр элсэж болно.



Гишүүдийн тоо 20 хүрэхгүй болсон тохиолдолд бүх гишүүдийн хурлыг хийнэ.



Гишүүн өр төлбөр, үүргийн гүйцэтгэлийг биелүүлээгүй бол аливаа гүйлгээ хийхийг хориглоно.



Ижил мэргэжилтэй, нэг байгууллагад ажилладаг, нэг аймаг, хот, дүүрэгт амьдардаг байх.



Бусад шаардлагыг ХЗХ өөрийн дүрмээр тогтоож болно.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГИШҮҮНИЙ ЭРХ ДУУСГАВАР БОЛОХ

Дараах тохиолдолд хоршооны гишүүний эрх нь **дуусгавар болно**:

- хоршооны гишүүний гишүүнчлэлээс гарах хүсэлтийг тэргүүлэгчдийн зөвлөл зөвшөөрсний дагуу гишүүнчлэлийн бүртгэлээс хассанаар;
- хоршооны гишүүн нь эрхээ бусдад шилжүүлж бүртгэлд өөрчлөлт хийснээр;
- тухайн ХЗХ-ны дүрмээр давхар гишүүнчлэлийг зөвшөөрөөгүй тохиолдолд, эсхүл өөр ХЗХ-нд давхар гишүүнчлэлтэй болсон.

Дараах тохиолдолд хоршооны гишүүний эрх **дуусгавар болсонд тооцогдоно**:

- гишүүн эрх зүйн бүрэн чадамжаа алдсан;
- гишүүн нас барсан буюу нас барсан гэж тооцогдсон;
- гишүүн хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан;
- ХЗХ татан буугдсанаар гишүүнчлэл дуусгавар болно.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГИШҮҮНИЙ ЭРХ



Дараах
эрхтэй

Бүх гишүүдийн саналын нэг эрхтэй оролцох

Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах саналыг гаргах

Мөнгөн хөрөнгөө хадгалуулах, зээл авах болон бусад үйлчилгээнд хамрагдах

Тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүнийг сонгох, сонгогдох

Өөрийн оруулсан хувь хөрөнгөө хууль, журмын дагуу бусдад шилжүүлэх, өв залгамжлуулах

Гишүүнчлэлээс гарах

Хууль бус үйл ажиллагааны талаар Хороонд гомдол гаргах

Хадгаламж, зээлийн хоршоо татан буугдсан тохиолдолд үлдсэн эд хөрөнгөөс оруулсан хувь хөрөнгөтэй хувь тэнцүүлэн хувь хөрөнгө авах


Хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр тогтоосон бусад эрх.

Хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр тогтоосон хязгаарын хүрээнд хувь хөрөнгө оруулах, өөрийн оруулсан хувь хөрөнгөтэй хувь тэнцүүлэн хадгаламж, зээлийн хоршооны жилийн орлогоос тогтоосон журмын дагуу хувь хөрөнгө авах



ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



"NVIDIA"-ИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ 3.4 ИХ НАЯД АМ.ДОЛЛАРТ ХҮРЧ ДЭЭД АМЖИЛТ ТОГТООЛОО.

Даваа гарагт хувьцааны үнэ 2.4 хувиар өсөж бүх цаг үеийн дээд түвшинд хүрч хаагдлаа.

6 дугаар сарын 18-нд хувьцааны үнэ 135.58 ам.долларт хүрч дээд амжилт тогтоож байсан бол 10 дугаар сарын 14-ний өдрийн хаалтаар 138.07 ам.долларт хүрч шинэ дээд амжилт тогтоолоо. Тус компанийн хувьцаа он гарснаас хойш 180 гаруй хувиар, 2023 оны эхэн үеэс 9 дахин өссөн байна.

2022 оны 11 дүгээр сард ChatGPT-ийг олон нийтэд худалдаанд гаргаснаар хиймэл оюун ухааны үүсгүүрийн

өсөлтөөс хамгийн их ашиг хүртэж байгаа компани нь Nvidia юм. Тус компанийн график боловсруулах нэгжүүд буюу GPU, ChatGPT болон үүнтэй төстэй программуудыг ажиллуулдаг дэвшилтэт AI загваруудыг бий болгоход ашигладаг.

Microsoft, Meta, Google болон Амазон зэрэг компаниуд тус AI-ийн дэвшилтэт ажилд зориулж том кластеруудыг бүтээхийн тулд Nvidia GPU-г их хэмжээгээр худалдан авч байна.

Nvidia-ийн орлого сүүлийн таван улирлын турш улирал бүр дор хаяж хоёроос гурав дахин өссөн үзүүлэлттэй байна. LSEG-ийн мэдээлснээр энэ оны үлдсэн хугацаанд эдийн засгийн өсөлт бага зэрэг удаашрах төлөвтэй байгаа бөгөөд 10 дугаар сарын төсгөлд 82 гаруй хувиар өсөж, 32.9 тэрбум ам.долларт хүрнэ гэж таамаглаж байна.

Тус компанийн зах зээлийн үнэлгээ нь 3.4 их наяд ам.доллар бөгөөд Apple-ийн дараа ордог хоёр дахь том компани юм.

Эх сурвалж: www.cnbc.com

ДЭЛХИЙ ДАХИНД ҮҮСЭЭД БУЙ ТОДОРХОЙГҮЙ БАЙДЛЫН УЛМААС АЛТНЫ ХАНШ ӨСӨЖ БАЙНА.

10 дугаар сарын 21 (Ройтерс) – Даваа гарагт алт дээд амжилт тогтоосон бөгөөд АНУ-ын сонгуультай холбоотой тодорхойгүй байдал, Ойрх Дорнод дахь хурцадмал байдал болон томоохон төв банкнуудын бодлогын хүүгээ бууруулах зэрэг нь уг өсөлтийг нэмэгдүүлж байна.

Өмнө нь 2,732.73 ам.долларт хүрч бүх цаг үеийн дээд цэгтээ хүрч байсан спот алт 0.3 хувиар өсөж, унц нь 2,729.40 ам.доллар болжээ. АНУ-ын алтны фьючерс 0.6 хувиар өсөж 2,744.80 ам.доллар болжээ.



Үнэт металлын ханш өссөнөөр спот мөнгөний ханш 1.1 хувиар өсөж, унц нь 34.0 ам.долларт хүрсэн нь 2012 оны сүүлчээс хойших хамгийн өндөр үзүүлэлт юм.

2024 оны АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд ерөнхийлөгч асан Дональд Трамп болон дэд ерөнхийлөгч Камала Харрис нарын өрсөлдөөн 11 дүгээр сарын 5-нд болох бөгөөд уг өрсөлдөөн нь ширүүн болж байгаа ба сонгуулийн үр дүнг таамаглахад хүндрэлтэй болгож байна.

Ойрх Дорнодод Ням гарагийн орой Бейрутын олон зуун оршин суугчид гэр орноо орхин дүрвэжээ. Мөн эдийн засаг, улс төрийн хямралын үед алтыг найдвартай хөрөнгө оруулалт

гэж үздэг учир алтны эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж байна.

Бусад үнэт металлын хувьд Цагаан алтны үнэ 0.3 хувиар өсөж, нэг унц нь 1,016.21 ам.доллар болсон нь 7 дугаар сарын дунд үеэс хойших хамгийн өндөр үзүүлэлт юм. Палладий 0.3 хувиар өсөж 1,076 ам.доллар болжээ.

Эх сурвалж: www.reuters.com



ХЯТАД УЛС ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХИЙН ТУЛД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ХҮҮГЭЭ БУУРУУЛЖ БАЙНА.

Эдийн засгийг сэргээх багц арга хэмжээний хүрээнд өнгөрсөн сард бусад бодлогын хүүгээ бууруулсны дараагаар Хятад улс даваа гаригт сар бүр тогтоодог жишиг зээлийн хүүгээ буурууллаа.

Нэг жилийн зээлийн үндсэн хүү (LPR) 3.35 хувиас 0.25 пунктээр буурч 3.10 хувь болсон бол таван жилийн зээлийн хүү 3.85 хувиас 3.60 хувь хүртэл буурчээ.

Хамгийн сүүлд 7 дугаар сард зээлийн хүүг бууруулсан.

10 дугаар сарын 21-нд Хятадын Ардын Банкны (PBOC) Ерөнхийлөгч Пан Гоншэн өнгөрсөн долоо хоногт болсон санхүүгийн форумын үеэр зээлийн хүүг 0.20-0.25 пунктээр буурна гэж мэдэгдсэн.

9 дүгээр сарын 24-ний өдөр PBOC банкнуудын заавал байлгах нөөцийн хэмжээг 0.50 пунктээр, долоон өдрийн урвуу репогийн жишиг хүүг 0.20 пунктээр бууруулснаа зарласан нь унасан хөрөнгийн салбарыг дэмжих арга хэмжээг багтаасан тахал өвчнөөс хойших хамгийн түрэмгий өдөөлтийг эхлүүлсэн юм. мөн хэрэглээг нэмэгдүүлнэ.

Хятадад шинэ болон төлөгдөөгүй ихэнх зээлүүд нь нэг жилийн хугацаатай зээлийн гэрээнд суурилдаг бол таван жилийн хүү нь ипотекийн зээлийн үнэд нөлөөлдөг.

9 дүгээр сарын 24-ний хэмжүүрээс хойш CSI300 индекс өдөр тутмын гүйлгээний рекордыг эвдэж, 14 хувиас илүү өссөн. Энэ хугацаанд юанийн ам.доллартой харьцах ханш 1 хувиар буурчээ.

Баасан гарагийн тоо баримтаас харахад Хятадын эдийн засгийн өсөлт гуравдугаар улиралд хүлээгдэж байснаас арай илүү гарсан ч үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт оны эхний есөн сард 10 гаруй хувиар буурсан. 9 дүгээр сард жижиглэнгийн худалдаа, аж үйлдвэрийн үйлдвэрлэл өссөн байна.

Эх сурвалж: www.reuters.com

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр

S&P 500 (^GSPC)

5,823.52 +15.40 (+0.27%)



Nikkei 225 (^N225)

38,903.68 +298.15 (+0.77%)



FTSE 100 (^FTSE)

8,285.62 +36.78 (+0.45%)



NASDAQ Composite (^IXIC)

18,567.19 +48.58 (+0.26%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia

